



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ




НҮБ-ын Хүүхдийн Сан



World Health
Organization

ДЭЛХИЙ ДАХИНЫ СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУДАЛГАА, GSHS-2023



БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАН ҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Улаанбаатар хот
2024 он



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



НҮБ-ын Хүүхдийн Сан



World Health
Organization

ДЭЛХИЙ ДАХИНЫ СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУДАЛГАА, GSHS-2023

БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАН ҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ



Улаанбаатар хот
2024 он

ГАРЧИГ

Өмнөх үг	5
Талархал	6
Товчилсон үгийн тайлбар	9
Судалгааны үндсэн үр дүнгийн хураангуй	10
БҮЛЭГ 1. ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ	20
1.1 Оршил	20
1.2 Өсвөр үеийнхний эрүүл мэнд дэлхий дахинд	20
1.3 Монгол улсын өсвөр үеийнхний эрүүл мэнд	21
1.4 Судалгааны зорилго, зорилтууд	22
1.5 Судалгааны шинэлэг тал	22
1.6 Судлагдсан байдал	22
БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ	24
2.1. Судалгааны хамрах хүрээ	24
2.2. Түүврийн хэмжээ, түүвэрлэлт	24
2.3. Судалгааны асуумж	24
2.4. Мэдээлэл боловсруулалт, жинлэлт, дүн шинжилгээ	25
2.5. Судалгааны арга зүйн сургалт	25
2.6. Мэдээлэл цуглуулалт	25
2.7. Судалгааны ёс зүйн асуудал	26
2.8. Судалгаанаас хасах болон судалгаанд хамруулах шалгуур	26
2.9. Судалгааны хязгаарлагдмал байдал	26
БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	27
3.1. Хүн ам зүй	27
3.2. Хоол хүнсний хэрэглээ	28
3.3. Эрүүл ахуйн дадал	31
3.4. Осол гэмтэл, хүчирхийлэл	33
3.5. Сэтгэцийн эрүүл мэнд	38
3.6. Тамхины хэрэглээ	41
3.7. Архи, согтууруулах ундааны хэрэглээ	44
3.8. Нөхөн үржихүйн эрүүл мэнд	47
3.9. Хамгаалах хүчин зүйлс	50
БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	54
Ерөнхий зөвлөмж	56
Хавсралтууд	60
Ашигласан хэвлэлийн жагсаалт	98



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1.** Судалгаанд хамрагдсан суралцагчдын хувь, нас, хүйсээр
- Хүснэгт 2.** Судалгаанд хамрагдсан суралцагчдын хувь, хүйс, ангиар
- Хүснэгт 3.** Тураал, илүүдэл жин, таргалалттай суралцагчдын хувь, хүйс, байршлаар
- Хүснэгт 4.** Жимсний хэрэглээ, хүйсээр (сүүлийн 7 хоногоор)
- Хүснэгт 5.** Хүнсний ногооны хэрэглээ, хүйсээр (сүүлийн 7 хоногоор)
- Хүснэгт 6.** Хийжүүлсэн ундааны хэрэглээ, хүйсээр (сүүлийн 7 хоногоор)
- Хүснэгт 7.** Чихэрлэг ундааны хэрэглээ, хүйсээр (сүүлийн 7 хоногоор)
- Хүснэгт 8.** Номхон далайн баруун бүсийн зарим орнуудын суралцагчдын осол гэмтэлд өртсөн, зодолдсон, бусдад дээрэлхүүлсэн хувь
- Хүснэгт 9.** Суралцагчдын сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд, хүйсээр (сүүлийн нэг жилээр)
- Хүснэгт 10.** Хамгийн багадаа нэг өдөр тамхи татсан суралцагчдын хувь, хүйс ба насны бүлгээр (сүүлийн нэг сараар)
- Хүснэгт 11.** Электрон тамхи 14 наснаасаа өмнө татаж үзсэн суралцагчдын хувь, хүйс, насны бүлэг, анги, байршлаар
- Хүснэгт 12.** Согтууруулах ундаа хэрэглэсэн суралцагчдын хувь, хүйсээр (сүүлийн нэг сараар)
- Хүснэгт 13.** Нэг болон түүнээс дээш удаа “согтотлоо уусан” суралцагчдын хувь насны бүлэг, байршил, хүйсээр
- Хүснэгт 14.** Эцэг эх, асран хамгаалагч нар эд зүйлсэд нь зөвшөөрөлгүй хүрсэн суралцагчдын хувь, (нас, хүйс, байршлаар)
- Хүснэгт 15.** Хамгаалах хүчин зүйлсийн талаарх асуултанд хариулсан суралцагчдын хувь, хүйсээр (сүүлийн нэг сараар)



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1.** Гэрт нь хоол хүнс хангалтгүйгээс өлссөн суралцагчдын хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)
- Зураг 2.** Шүдээ угаагаагүй болон өдөрт нэгээс бага угаадаг суралцагчдын хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)
- Зураг 3.** Гар угаах зохисгүй дадалтай суралцагчдын эзлэх хувь, байршлаар ба хүйсээр, (сүүлийн нэг сараар)
- Зураг 4.** Осол гэмтэлд өртсөн хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг жилээр)
- Зураг 5.** Суралцагчдад тохиолдсон аюултай осол, гэмтлийн хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг жилээр)
- Зураг 6.** Зам тээврийн осолд өртсөн хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг жилээр)
- Зураг 7.** Суралцагчдын бусадтай зодолдсон хувь, байршил ба хүйсээр, (сүүлийн нэг жилээр)
- Зураг 8.** Сургуулийн орчинд дээрэлхэлтэд өртсөн хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)
- Зураг 9.** Цахим хүчирхийлэлд өртсөн хувь, хүйсээр (сүүлийн нэг жилээр)
- Зураг 10.** Хүчирхийлэлд өртсөн суралцагчдын хувь, төрлөөр (сүүлийн нэг жилээр)
- Зураг 11.** Амиа хорлох талаар бодож байсан болон оролдлого хийсэн хувь, байршлаар (сүүлийн нэг жилээр)
- Зураг 12.** Тамхийг ганц, хоёр удаа сорж, туршиж үзсэн болон 14 наснаасаа өмнө татсан суралцагчдын хувь, хүйсээр
- Зураг 13.** Дам тамхидалтад өртсөн суралцагчдын хувь, байршил ба хүйсээр (сүүлийн долоо хоногоор)
- Зураг 14.** Электрон тамхины хэрэглээ, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)
- Зураг 15.** 14 наснаасаа өмнө архи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн суралцагчдын хувь, байршил ба хүйсээр
- Зураг 16.** Архи, согтууруулах ундааг 2 уулт болон 6 уултаас дээш хэмжээгээр хэрэглэсэн байдал, байршлаар
- Зураг 17.** Бэлгийн харьцаанд орсон суралцагчдын хувь, байршил ба хүйс
- Зураг 18.** Хоёр ба түүнээс олон хүнтэй бэлгийн харьцаанд орсон суралцагчдын хувь, байршил ба хүйсээр
- Зураг 19.** Хоёр ба түүнээс олон хүнтэй бэлгийн харьцаанд орсон суралцагчдын хувь, насны бүлгээр
- Зураг 20.** Сүүлийн бэлгийн харьцааны үед бэлгэвч болон жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгсэл хэрэглэсэн суралцагчдын хувь, хүйсээр
- Зураг 21.** Шалтгаангүйгээр хичээлээ тасалсан суралцагчдын хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)
- Зураг 22.** Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ гэрийн даалгаварт тавих хяналт, хүйс ба байршлаар
- Зураг 23.** Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгааг эцэг эх, асран хамгаалагч нар нь анхаардаггүй байдал, хүйс ба байршлаар



ӨМНӨХ ҮГ



Хүний хөгжлийн хамгийн эрчимтэй, чухал үе болох хүүхэд, өсвөр үеийнхний өсөлт хөгжил, тэдний эрүүл мэнд, боловсролыг дэмжих нь насан туршид нь өгөөжөө өгөх ухаалаг хөрөнгө оруулалт болдог. Хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, халамж асаргаа, хөгжих боловсрох эрх, хүүхэд хамгааллын асуудлыг нэгдмэл хандлага, арга зүйгээр дэмжиж ажиллах нь дэлхий нийтэд болон Монгол улсын хөгжлийн тэргүүлэх зорилтуудын нэг байдаг.

Нийгэм, эдийн засаг, байгаль орчны харилцан тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн “Тогтвортой хөгжлийн Дэлхийн зорилт-2030”, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгагдсан 17 зорилго тус бүрийг нэг салбарын үйл ажиллагаа бусад салбаруудад шууд нөлөөлөхүйц бодлогоор нягт уялдуулсан байдаг бөгөөд хүүхдийн хүмүүжил төлөвшил, нийгэмшил, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлууд төрөөс энэ чиглэлээр үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжээс шууд хамааралтай.

Иймээс 2022-2023 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, Шинжлэх ухааны яам хамтран “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа”-г үндэсний хэмжээнд хот, хөдөөгийн 51 сургуулийн 8-12 дугаар ангийн нийт 3311 хүүхдийг хамруулан амжилттай гүйцэтгэн, үр дүнг нь танилцуулж байгаадаа баяртай байна.

Судалгаагаар Монгол улсын Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах эрхээс гадна тэдний хоол тэжээлийн байдалд үнэлгээ өгч, эрүүл мэндийн эрсдэлт зан үйл, осол гэмтэл, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, архи, тамхины хэрэглээ, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл ахуйн дадлыг хүн амын суурьшил, нас хүйсээр нь ялган тодорхойлж, 2010, 2013 онуудад хийгдсэн өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулсан байна.

Судалгаагаар 6 суралцагч тутмын 1 нь илүүдэл жин ба таргалалттай, 4 суралцагч тутмын 1 нь электрон тамхи, 10 суралцагч тутмын 1 нь янжуур тамхи татдаг, 6 суралцагч тутмын 1 нь цахим гадуурхалд өртөж байгаа зэрэг анхаарал татахуйц үр дүн гарсан нь өсвөр үеийнхний амьдралын чанар, сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлж, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эрүүл мэндийн боловсролыг сайжруулах чиглэлээр нотолгоонд тулгуурласан, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого боловсруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Хүн бүр эрүүл мэндийн мэдлэгтэй байж, хувийн үүрэг хариуцлагаа ухамсарлан дээшлүүлж, амьдралаа зөв төлөвлөснөөр цаашид эх орныхоо хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад бодитой хувь нэмэр оруулах боломжтой юм.

Хүн амын эрүүл мэндийн төлөө хамтдаа зүтгэе!

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД СОДНОМЫН ЧИНЗОРИГ**



ТАЛАРХАЛ



Дэлхийн олон орны Засгийн газар эрүүл мэнд болон боловсролын байгууллагаар дамжуулан 2003 оноос өөрийн орны оюутан, сурагчдын эрүүл мэндийн зан үйлийн эрсдэл болон хамгаалах хучин зүйлсийн тархалтыг тогтоох, хянах зорилгоор “Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа, (GSHS)”-г хийсээр ирсэн.

Манай улс 2010, 2013 онуудад “Сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа”-г үндэсний хэмжээнд АНУ-ын Өвчин судлалын төв, Монголын мянганы сорилтын сангийн эрүүл мэндийн төсөл, ДЭМБ-ын техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр 2 удаа амжилттай зохион байгуулсан.

Өсвөр насны хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн өнөөгийн байдлыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалын дагуу судлан, тогтоож, засгийн газрын бодлого, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох, суурь мэдээллийг бий болгох зорилгоор НҮБ-ын Хүүхдийн Сан, ДЭМБ-ын санхүүгийн болон техникийн дэмжлэгтэйгээр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн судалгаа”-г 2022-2023 онд гүйцэтгэн, үр дүнг тайлагнан хамтрагч талууддаа хүргэж байгаадаа судлаачид бид туйлын баяртай байна.

Үндэсний түвшинд хийгдсэн тус судалгааг зохион байгуулахад удирдлага, арга зүйгээр ханган ажилласан тус судалгааны санаачлагч НХХЯ-ны ажлын хэсгийн дарга, гишүүдэд болон судалгааны арга аргачлалыг хэлэлцэн, үнэтэй зөвлөгөө өгсөн НЭМҮТ-ийн Эрдмийн зөвлөл, үндэсний хэмжээнд судалгаа хийх зөвшөөрөл олгосон ЭМЯ-ны Ёс зүйн хяналтын хороо, ҮСХ-ны Арга зүйн байнгын зөвлөлд талархаж буйгаа судалгааны багийн нийт хамт олны нэрийн өмнөөс илэрхийлж байна.

Судалгаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн НҮБХС-гийн удирдлага, хамт олон болон ДЭМБ-ын арга аргачлалаар судалгааг гүйцэтгэхэд техник арга зүйн дэмжлэг үзүүлсэн Монгол Улс дахь ДЭМБ-ын Суурин төлөөлөгч Сокорро Эскаланте, Женев дэх ДЭМБ-ын Халдварт бус өвчний асуудал хариуцсан албаны, Тандалт, хяналт, тайлагналтын нэгжийн дарга Лэанн Райли, Зөвлөх Лоура Кэнн, мэргэжилтэн Мэлани Коуэн, ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн мэргэжилтэн Тико Жозэя болон Монгол Улс дахь ДЭМБ-ын Суурин төлөөлөгчийн газрын мэргэжилтэн С.Болормаа нартаа маш их баярлалаа.

ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газар, аймаг, нийслэлийн Боловсролын газрын хамт олон болон энэхүү судалгаанд хувь, нэмрээ оруулсан бүх хүмүүст судалгааны багийн өмнөөс гүн талархал илэрхийлье!

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ, СУДАЛГААНЫ УДИРДАГЧ,
ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР С.ӨНӨРСАЙХАН**



Хэрэгжүүлэгч байгууллага

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Хамтран ажилласан байгууллагууд

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Эрүүл мэндийн яам
Боловсрол, Шинжлэх ухааны яам
Нийслэлийн Боловсролын газар
Аймаг, дүүргийн Боловсролын газар
Сонгогдсон Ерөнхий боловсролын сургуулиуд

Олон улсын зөвлөх байгууллага

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
Женев дэх Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Төв оффис
Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн Сан

Судалгааны ажлын хэсэг

Н.Баярмаа	ХНХЯ-ны ГББХЗГ-ын дарга
Э.Эрдэнэсан	ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын дарга
Д. Амарбаа	НҮБ-ын Хүүхдийн сангийн ахлах мэргэжилтэн
Д.Ариунзаяа	НҮБ-ын Хүүхдийн сангийн ахлах мэргэжилтэн
Ч.Батаа	НҮБ-ын Хүүхдийн сангийн ахлах мэргэжилтэн
С.Болормаа	ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын мэргэжилтэн
С.Санжаабадам	БСҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Ж.Азжаргал	ХНХЯ-ны ГББХЗГ-ын мэргэжилтэн
Б.Дуламсүрэн	БШУЯ-ны ЕББУЗГ-ын шинжээч
Б.Дөлгөөн	ЭМЯ-ны НЭМГ-ын мэргэжилтэн
Ч.Анаргоо	НЭМҮТ-ийн гадаад харилцааны мэргэжилтэн

Судалгааны удирдагч

С.Өнөрсайхан ХУ-ы доктор, дэд профессор, НЭМҮТ-ийн Захирал

Судалгааны зөвлөхүүд

А.Амарбал	Ахлах зөвлөх Нийслэлийн Бодлогын судалгаа, шинжилгээний төвийн Нийгэм, эдийн засгийн судалгааны газрын Захирал
С.Энхтуяа	Арга зүйн Зөвлөх
Лоура Кэнн	Женев дэх ДЭМБ-ын ХБӨ-ний асуудал хариуцсан албаны Тандалт, хяналт, тайлагналтын нэгжийн Зөвлөх

Судалгааны зохицуулагчид

Ц.Уянга	ХНХСҮСИ-ийн эрдэм шинжилгээний ажилтан
М.Цолмон	НЭМҮТ-ийн мэргэжилтэн



Тайлан бичсэн

Д.Дэлгэрмаа	ЭШАА, АУ-ы доктор, НЭМҮТ
И.Туяажаргал	ЭШАА, ХУ-ы доктор, НЭМҮТ
Л.Нямсүрэн	ЭШДэА, НЭМ-ийн магистр, НЭМҮТ
Г.Сэлэнгэ	ЭШДэА, НЭМ-ийн магистр, НЭМҮТ
У.Эрхэмбаяр	ЭША, НЭМҮТ
Т.Хосцэцэг	ЭША, НЭМҮТ
Г.Номуунтуул	ЭША, НЭМҮТ
Б.Нарангэрэл	ЭША, НЭМҮТ

Мэдээлэл цуглуулалтын баг

И.Туяажаргал	ЭШАА, НЭМҮТ
Б.Алтангэрэл	Судлаач
Х.Ган-Очир	Судлаач
Б.Төгөлдөр	ЭША, НЭМҮТ
У.Эрхэмбаяр	ЭША, НЭМҮТ
Э.Туяацэцэг	Судлаач
Ч.Мягмардорж	ЭША, НЭМҮТ
С.Цэрэндулам	Судлаач
С.Нургүл	Судлаач
Ц.Ууганбаяр	Судлаач
Г.Сэлэнгэ	ЭША, НЭМҮТ
Т.Хосцэцэг	ЭША, НЭМҮТ
Т.Мөнхбат	Судлаач
Г.Номуунтуул	ЭША, НЭМҮТ
М.Уянга	Судлаач
Б.Лхагважав	Судлаач

Хэвлэлийн эх бэлтгэсэн

Д.Дэлгэрмаа	АУ-ы доктор, НЭМҮТ
Э.Өлзийжаргал	БУ-ы доктор, НЭМҮТ

Тайланг орчуулсан

Б.Оюундарь	НЭМ-ийн магистр, Япон улсын Хирошимогийн Их сургуулийн докторант
------------	--

Хянан тохиолдуулсан

Монгол хэлнээ

С.Өнөрсайхан	ХУ-ы доктор, дэд профессор, НЭМҮТ
--------------	-----------------------------------

Англи хэлнээ

Д.Дэлгэрмаа	АУ-ы доктор, НЭМҮТ
-------------	--------------------

Жич: Судалгаанд хамаарах асуудлаар Та бүхний санал, зөвлөгөөг дараах хаягаар баяртайгаар хүлээн авах болно.

Хаяг: Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Энх тайвны гудамж-17, Улаанбаатар-210349

Цахим хуудас: www.ncph.gov.mn

Цахим хаяг: unursaikhan.suren@gmail.com



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн нэгдсэн улс
АУ	Анагаах ухаан
БУ	Биологийн ухаан
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БЖИ	Биеийн жингийн индекс
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам
БШУЯ	Боловсрол, Шинжлэх ухааны яам
БСҮХ	Боловсрол судлалын үндэсний хүрээлэн
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДДССЭМС	Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕББУЗГ	Ерөнхий боловсролын Бодлого, удирдлага зохицуулалтын газар
ИХ	Итгэх хязгаар
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
НЭМГ	Нийтийн эрүүл мэндийн газар
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
НДББ	Номхон далайн баруун бүс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХС	НҮБ-ын Хүүхдийн сан
НҮББСШУТ	НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны төв
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУБ	Олон улсын байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨХСТ	Өвчний хяналт, сэргийлэлтийн төв
СХ	Стандарт хазайлт
ШУ	Шинжлэх ухаан
ШУТ	Шинжлэх ухаан технологи
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ХБӨ	Халдварт бус өвчин
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам
ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
ХУ	Химийн ухаан
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭК	Хүүхдийн эрхийн тухай конвенц
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан
ЭШАА	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
GSHS	Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа



СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Өсвөр насны хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн өнөөгийн байдлыг ДЭМБ болон НҮБХС, НҮББСШУТ, Халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төвийн дэмжлэгтэйгээр 2001 онд боловсруулсан “Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгааны арга, аргачлал”-ын дагуу хийж, Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох, нотолгоонд сууилсан суурь мэдээллийг бий болгох зорилгоор НҮБ-ын Хүүхдийн Сан, ДЭМБ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын судалгааны үндэсний төвүүд хамтран “Боловсролын орчин дахь хүүхдийн эрүүл мэндийн зан үйлийг тодорхойлох судалгаа”-г 2022-2023 онд хийж, гүйцэтгэлээ.

Материал, арга зүй: Үндэсний түвшинд 2022-2023 оны хичээлийн жилийн 4-р улиралд хийсэн энэхүү судалгаанд хот, хөдөөгийн Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцдаг 8-12 дугаар ангийн суралцагчдыг хамрууллаа. Хоёр шатлалт, санамсаргүй түүврийн аргаар хот, хөдөөгөөс нийт 51 (хот-26, хөдөө-25) Ерөнхий боловсролын сургуулийн 3857 хүүхэд судалгаанд оролцох боломжтойгоор сонгогдсоноос нийт 3311 суралцагчдыг судалгаанд хамруулсан.

Эхний шатны түүвэрлэлтийг Женев дэх ДЭМБ-ын ХБӨ-ний асуудал хариуцсан албаны Тандалт, хяналт, тайлагналтын нэгжийн судалгааны түүвэрлэлтийн асуудал эрхэлсэн баг хийж, стандарт аргачлалын дагуу судалгаанд хамрагдах 51 сургуулийг пропорциональ хуваарилалтын аргаар сонгосон. Дараагийн шатанд сонгогдсон аймаг, дүүргийн ЕБС-ийн нийт анги, бүлэг, хүүхдийн тоонд үндэслэн санамсаргүй түүврийн аргаар судалгаанд оролцох анги, бүлгийг сонгосон. Сонгогдсон ангиуд нь бүгд түүврийн хэмжээнд багтсан бөгөөд тухайн ангийн нийт сурагчдад судалгаанд оролцох эрхтэй байхаар боломжийг бүрдүүлсэн. Хоёр шатлалт санамсаргүй түүврийн аргаар хийгдсэн энэхүү судалгааны үр дүн 95 хувийн магадлалтай, алдааны хязгаар 5 хувиас хэтрэхгүй байхаар түүврийн хэмжээг тогтоосон болно.

Сонгогдсон ангиудад суралцаж буй бүх суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч нараас судалгаанд сайн дураар оролцох талаар асууж, таниулсан зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрөл авсан.

Судалгаагаар сурагч, өсвөр насны хүүхдүүдийн дундах эрүүл мэнд, зан үйлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлохыг зорьсон.

Судалгааны асуумж нь дараах 9 бүлэг бүхий нийт 74 асуултаас (хавсралт) бүрдсэн.

1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд
2. Хүнс, хоолны хэрэглээ
3. Эрүүл ахуйн дадал
4. Осол гэмтэл, хүчирхийлэл
5. Сэтгэцийн эрүүл мэнд
6. Тамхины хэрэглээ
7. Архины хэрэглээ
8. Хамгаалах хүчин зүйлс
9. Бэлгийн зан үйл

ДЭМБ, НҮБХС, НҮББСШУТ, АНУ-ын ӨХСТ-ийн мэргэжилтнүүдийн хамтран боловсруулсан Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаанд ашиглагддаг Дэлхийн НДББ-ийн нийт 104 улс оронд хийгдсэн 10 модуль асуумжийг үндэслэн манай орны нөхцөлд тохирох байдлаар шинэчлэн боловсруулсан 8 модуль бүхий 74 асуулгаас бүрдсэн.

Судалгааг 2023 оны 4 дүгээр сарын 17-ноос 5 дугаар сарын 13-ны хооронд сонгогдсон аймаг, дүүргийн сургуулиудад үндэсний түвшинд гүйцэтгэсэн. Судалгааны баг нь багийн ахлагч болон үндсэн 3 судлаачийн бүрэлдэхүүнтэй нийт 4 багийн 16 судлаач талбарт ажилласан ба сонгогдсон орон нутгийн туслах мэргэжилтнүүдтэй хамтран судалгааны мэдээллийг цуглуулсан.

Үр дүн. Судалгаанд хотын 26, хөдөөгийн 25 төрийн болон хувийн ЕБС-ийн 8-12 дугаар ангийн нийт 3311 суралцагч хамрагдсаны 47.9% нь эрэгтэй, 52.1% нь эмэгтэй байлаа.



Хоол, хүнсний хэрэглээ.

Суралцагчдын жин, өндрийг хэмжиж, бие бялдрын өсөлт, хөгжилт, БЖИ-ийг нь үнэлж, ДЭМБ-аас гаргасан өсөлтийн муруй ашиглан тураал, илүүдэл жин, таргалалтыг тогтоосон. БЖИ-ийн үнэлгээгээр нийт суралцагчдын 3.2% нь тураалтай, 14.6% нь илүүдэл жинтэй, 3.0% нь таргалалттай байна.

Сүүлийн нэг сард гэрт нь хангалттай хоол, хүнс байгаагүйгээс өлссөн суралцагчдын хувь 3.1% (95%CI 2.1-4.5) байна. Сүүлийн 7 хоногт нийт суралцагчдын 32.0% нь огт жимс идээгүй бол 89.0% нь нэгээс илүүгүй удаа жимс идсэн, хүнсний ногоог огт хэрэглээгүй суралцагчид 2.9% (95%CI 2.1-3.9) байсан бөгөөд энэ үзүүлэлт нь хөдөө орон нутгийн суралцагчдын (5.7%, 95%CI 4.8-6.7) хувьд анги ахих тутам ихсэж байв.

Суралцагчдын хийжүүлсэн ундаа хэрэглээ нь байршил болон хүйсийн хувьд ялгаа ажиглагдаагүй, харин анги ахих тутам хэрэглээ нь буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Эрүүл ахуйн дадал

Суралцагчдын 6.5% (95% CI 5.1-8.1) нь сүүлийн нэг сард удаа шүдээ огт угаагаагүй болон өдөрт нэгээс цөөн удаа угаасан байв. Энэ сөрөг дадал нь анги ахихад буурах хандлагатай байна. Нийт суралцагчдын 34.0% (95% CI 30.0-38.3) шүдээ угаахдаа фтортой оо хэрэглэдэг бол хот, хөдөөд ялгаатай байдал ажиглагдсангүй.

Сүүлийн нэг сард амны хөндийн эрүүл мэндийн шалтгаанаар хичээлээ тасалсан суралцагчид 8.0% (95% CI 6.3-10.0) бөгөөд хотод 7.7% (95% CI 5.6-10.5), хөдөөд 8.9% (95% CI 7.0-11.1) байна. Энэ үзүүлэлт нь хүйсийн хувьд ялгаагүй ба 16-17 насны суралцагчдын дунд их байна.

Суралцагчдын 4.2% (95% CI 3.1-5.7) нь сүүлийн нэг сард ариун цэврийн өрөө, жорлон орсны дараа гараа огт угаагаагүй болон ховор угаасан байна. Энэ сөрөг дадал нь анги ахихад буурч байв.

Осол, гэмтэл хүчирхийлэл

Нийт суралцагчдын 39.6% (95%CI 36.4-42.8) нь сүүлийн нэг жилд осол гэмтэлд өртсөн бөгөөд эрэгтэй суралцагчдын (41.7%, 95%CI 37.6-45.9) дунд илүү байна. Насны бүлгээр нь харьцуулахад статистик ялгаа ажиглагдсангүй. Харин байршлын хувьд хотод (41.3%, 95%CI 37.1-45.6) хөдөөгөөс (33.9%, 95%CI 29.5-38.7) илүү байв.

Нийт суралцагчдын 24.9% (95%CI 20.6-29.7) яс хугарсан, үе мултарсан, шүд хугарсан зэрэг аюултай осол гэмтэлд өртсөн бөгөөд энэ үзүүлэлт эрэгтэй суралцагчдад (31.5%, 95%CI 25.7-38.0) илүү байна.

Сүүлийн нэг жилд зам тээврийн осолд орж тээврийн хэрэгсэлд мөргүүлснээс шалтгаалж осол, гэмтэлд өртсөн суралцагчид 5.4% (95%CI 3.9-7.4) байгаа нь 2013 оны судалгааны дүнгээс буурсан сайн үзүүлэлттэй байна.

Нийт суралцагчдын 23.3% (95%CI 21.2-25.6) нь сүүлийн нэг жилийн хугацаанд бусдад зодуулсан бөгөөд энэ үзүүлэлт эрэгтэй суралцагчдын хувьд их байна. Харин бусадтай зодолдсон байдал нь нийт суралцагчдын 28.3% (95%CI 26.1-30.6) ба анги ахих тутам буурч байлаа. Байршлын хувьд хот (37.2%, 95%CI 33.1-41.5) хөдөөд (38.8%, 95%CI 34.8-42.8) ялгаагүй эрэгтэй суралцагчид илүү бусадтай зодолдсон байна.

Суралцагчдын цахим хүчирхийлэлд өртсөн байдал 17.7% (95%CI 16.4-19.0) байгаа бөгөөд ихэвчлэн эмэгтэй суралцагчид эрэгтэй суралцагчдаасаа илүү өртөж байна.

Багш нарын шийтгэл, дарамтыг 10 суралцагч бүрийн 3 нь мэдэрдэг байна.

Сэтгэцийн эрүүл мэнд

Суралцагчдын 24.3% (95%CI 22.2-26.4) байнга ганцаарддаг байх бөгөөд эмэгтэй суралцагчдын ганцаарддаг хувь эрэгтэй суралцагчдаас ойролцоогоор 2 дахин их байна.

12.5% (95%CI 10.8 - 14.5) нь ямар нэг зүйлд санаа зовсноос болж шөнө унтаж чадаагүй бөгөөд энэ үзүүлэлт эмэгтэй суралцагчдад (16.4%, 95%CI 14.0 - 19.1) 2 дахин их тохиолдож байна.



Сүүлийн нэг жилийн хугацаанд амиа хорлох талаар бодож байсан 39.0% (95%CI 36.3-41.8), төлөвлөж байсан 22.2% (95%CI 20.0 - 24.6), нэг ба түүнээс олон удаа оролдлого хийсэн 15.8% (95%CI 13.8-18.0) байна.

Дотны сайн найзгүй гэж хариулсан суралцагчдыг хүйсийн хувьд харьцуулахад эмэгтэй суралцагчид 9.9% (95%CI 7.7-12.5), эрэгтэй суралцагчдын хувьд 6.6% (95%CI 5.3-8.2) байна.

Тамхины хэрэглээ

Суралцагчдын 19.9% нь тамхи татаж үзсэн байна. Тамхи татаж үзсэн нийт суралцагчдын 38.4% (95%CI 35.2-41.6) нь тамхийг ганц, хоёр удаа сорж, туршиж үзсэн бол 56.5% нь (95%CI 51.1-61.7) 14 наснаасаа өмнө тамхи татсан байна. 14 түүнээс бага насандаа тамхи татаж үзсэн сурагчдыг хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэй (58.7%, 95%CI 51.8-65.2) суралцагчид эмэгтэй (52.4%, 95%CI 44.9-59.7) суралцагчдаас илүү байв.

Дам тамхидалтад өртсөн суралцагчдын хувь хотод 64.4% (95%CI 59.4-69.1), хөдөөд 58.7% (95%CI 53.6-63.6) байв. Судалгааны дүнгээс харахад хотын суралцагчид дам тамхидалтад илүү өртөж байна. Харин хүйсийн хувьд хот, хөдөөд ялгаагүй ахлах ангийн эрэгтэй суралцагчид дам тамхидалтад өртөх нь их байна.

Нийт суралцагчдын 24.8% (95%CI 20.9-29.2) нь сүүлийн 30 хоногт электрон тамхи татсан байв. Энэ үзүүлэлт ахлах ангийн эрэгтэй суралцагчидад илүү байна.

Архины хэрэглээ

Нийт суралцагчдын 42.3% (95%CI 34.4-50.5) нь архи, согтууруулах ундааг 14 нас хүрэхээсээ өмнө хэрэглэж үзсэн байна. Мөн суралцагчдын 39.2% (95% CI 31.8-47.0) нь 2 уулт ба түүнээс дээш хэмжээгээр архи, согтууруулах ундааг хэрэглэсэн байна. Насны бүлгээр харахад 16-17 насны суралцагчид (43.8%, 95%CI 32.5-55.5) бусад насны бүлгээсээ их байв.

Насанд хүрээгүй архи, согтууруулах ундаа худалдан авахыг оролдсон тохиолдол 50.4% (95%CI 39.8-61.0), гэр орны нөхцөлд согтууруулах ундааг хэрэглэж (66.1%, 95%CI 60.8-71.1), ямар нэг асуудалд орсон, эсхүл зодоон цохионд холбогдсон (3.8%, 95%CI 2.8-5.2) байдал байршлын хувьд ялгаагүй 16-17 насны эрэгтэй суралцагчдын хувьд илүү үзүүлэлттэй байна.

Бэлгийн зан үйл

Нийт суралцагчдын 18.9% (95%CI 16.4-21.8) буюу ойролцоогоор 5 суралцагч тутмын 1 нь бэлгийн харьцаанд орж үзсэн байна. Бэлгийн харьцаанд орсон үзүүлэлт хотод 19.5% (95%CI 16.2-23.3) хөдөөд 16.6% (95%CI 13.5-20.2) байв.

Суралцагчдын бэлгийн харьцаанд орсон гол шалтгаан нь “Миний бүх найзууд бэлгийн харьцаанд ороод үзчихсэн учраас” гэж эрэгтэй суралцагчдын 4.0% (95%CI 2.1-7.8), эмэгтэй суралцагчдын 2.6% (95%CI 0.8-7.7) тайлбарлажээ.

Бэлгийн харьцаанд орсон суралцагчдын 24.3% (95%CI 15.8-35.5) буюу 4 суралцагч тутмын 1 нь 14 нас хүрэхээсээ өмнө анх бэлгийн харьцаанд орсон байна. Үүнийг хүйсээр авч үзвэл эрэгтэй суралцагчид 19.4% (95%CI 11.2-31.4), эмэгтэй суралцагчид 30.4% (95%CI 20.2-43.0) байна.

Суралцагчдын 5.7% (95%CI 4.2-7.7) 2 ба түүнээс олон хүнтэй бэлгийн харьцаанд орсон байна. Энэ үзүүлэлт нь хотод 6.0% (95%CI 4.1-8.8), хөдөө 4.7% (95%CI 3.2-6.9) байгаа бол эрэгтэй 10 суралцагч тутмын 1 нь хоёр ба түүнээс олон хүнтэй бэлгийн харьцаанд орсон байна.

Бэлгийн харьцаанд орсон нийт суралцагчдын 63.9% (95%CI 55.8-71.3) үүнээс эрэгтэй суралцагчид 70.8% (95%CI 63.9-76.9), эмэгтэй суралцагчид 55.1% (95%CI 43.3-66.4) нь хамгийн сүүлд бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна.

Мөн суралцагчдын 3.4% (95%CI 2.1-5.5) нь хамгийн сүүлд бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвчнээс бусад төрлийн жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэл хэрэглэсэн байна.

Хамгаалах хүчин зүйлс

Нийт суралцагчдын 26.5% (эрэгтэй-27.8%, 95%CI 23.8-32.1, эмэгтэй-25.2%, 95%CI 20.5-30.7) нь сүүлийн нэг сард ямар нэгэн шалтгаангүйгээр хичээлээ тасалсан байна. Эрэгтэй суралцагчдын

шалтгаангүйгээр хичээл таслалт эмэгтэйгээс суралцагчдаас илүү байв. Харин байршил, насны бүлгээр харьцуулан авч үзвэл хөдөөгийн суралцагчид (32.2%, 95%CI 29.3-35.3) болон 16-17 насны эрэгтэй суралцагчид (44.5%, 95%CI 37.3-51.9)-ын шалтгаангүйгээр хичээл тасалсан байдал илүү байна.

Сүүлийн нэг сард эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ гэрийн даалгавраа хийсэн эсэхийг тогтмол шалгаж байсан нь 21.5% (95%CI 19.8-23.3)-тай байв. Суралцагчдын нас, анги ахих тутам эцэг эх, асран хамгаалагч нарын зүгээс тэдний гэрийн даалгавраа хийсэн эсэхэд хяналт тавих нь буурч байв.

Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ сэтгэлийг зовоож буй асуудлыг огт ойлгож, дэмждэггүй гэх суралцагчид 57.3% (95%CI 54.4-60.2)-тай байсан бөгөөд ялангуяа эрэгтэй суралцагчдын (60.6%, 95%CI 57.1-64.0) дунд энэ үзүүлэлт илүү хувьтай байлаа.

Суралцагчдын 25.9% нь эцэг эх, асран хамгаалагч нар нь хүүхдийнхээ чөлөөт цагийг хэрхэн өнгөрүүлж байгаад анхаарал хандуулдаггүй байна.

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ (ЕБС-ийн суралцагчид, хүйсээр)

БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАН ҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА, GSHS-2023

Боловсролын орчин дахь хүүхдийн эрүүл мэндийн зан үйлийг тодорхойлох судалгаа, GSHS-2023” судалгааны мэдээлэл цуглуулалтыг ДЭМБ-ын стандарт аргачлалын дагуу 2023 оны 4 дүгээр сарын 17-ноос 5 дугаар сарын 13-ны хооронд үндэсний хэмжээнд зохион байгуулав. Судалгааг 2 шатлалт, санамсаргүй түүврийн аргаар хот, хөдөөгөөс нийт 51 ЕБС-ийн 8-12 дугаар ангийн нийт суралцагчдыг оролцох боломжтойгоор сонгосон. Сонгогдсон ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч нараас судалгаанд оролцох зөвшөөрлийг таниулсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсгээр баталгаажуулан авсан. Судалгаанд сургуулийн хамрагдалтын түвшин 100%, суралцагчдын хамрагдалт 85.9% байв.

ЕБС-ийн 13-17 насны суралцагчдын дунд	Нийт %, (95% ИХ)	Эрэгтэй %, (95% ИХ)	Эмэгтэй %, (95% ИХ)
Хооллолтын хэв маяг			
Тураалтай суралцагчдын хувь (БЖИ дунджаас <-2СХ)	3.2 (2.4-4.4)	4.2 (3.0-5.9)	2.3 (1.5-3.6)
Илүүдэл жинтэй суралцагчдын хувь (БЖИ-ийн дунджаас >+1СХ)	14.6 (12.1-17.4)	13.3 (10.2-17.1)	15.7 (13.3-18.5)
Таргалалтай суралцагчид (БЖИ-ийн дунджаас >+2СХ)	3.0 (2.2-4.2)	3.6 (2.3-5.5)	2.5 (1.7-3.6)
Сүүлийн 7 хоногт өдөрт нэг ба түүнээс олон удаа чихэрлэг ундаа уусан суралцагчдын хувь	10.1 (8.4-12.2)	8.5 (6.5-10.9)	11.4 (8.9-14.5)
Эрүүл ахуйн дадал, сүүлийн нэг сараар			
Шүдээ огт угаагаагүй болон өдөрт нэг түүнээс цөөн удаа угаадаг	6.5 (5.1-8.1)	8.3 (6.4-10.7)	4.8 (3.6-6.4)
Ариун цэврийн өрөөнд орсны дараа гараа огт угаадаггүй буюу ховор угаадаг	4.2 (3.1-5.7)	4.1 (2.8-5.9)	4.0 (2.9-5.6)
Осол гэмтэл, хүчирхийлэл, сүүлийн нэг жилээр			
Осол, гэмтэлд өртсөн байдал	39.6 (36.4-42.8)	41.7 (37.6- 45.9)	37.5 (32.8- 42.4)
Бусадтай зодолдсон байдал	28.3 (26.1-30.6)	37.8 (35.0- 40.7)	19.2 (16.8- 21.9)
Сургуулийн орчинд хүчирхийлэлд өртсөн байдал	26.9 (25.2-28.6)	28.6 (26.1- 31.2)	25.1 (22.5- 27.9)
Цахим хүчирхийлэлд өртсөн байдал	17.9 (16.5-19.3)	14.1 (12.3- 16.0)	21.3 (19.2- 23.6)
Сэтгэцийн эрүүл мэнд, сүүлийн жилээр			
Дотнын найзгүй суралцагчдын хувь	8.2 (6.8-10.0)	6.6 (5.3-8.2)	9.9 (7.7-12.5)
Амиа хорлох талаар бодож байсан	39.0 (36.3-41.8)	28.3 (24.6-32.3)	49.1 (45.1-53.2)
Амиа хорлох гэж нэг ба түүнээс олон удаа оролдож байсан	15.8 (13.8-18.0)	10.2 (8.0-12.9)	21.0 (18.1-24.1)

Тамхины хэрэглээ			
Сүүлийн 30 хоногт хамгийн багадаа нэг өдөр тамхи татсан	11.1 (9.0-13.5)	17.2 (14.0-20.8)	5.3 (4.0-7.1)
Тамхи татаж үзсэн суралцагчдын хувь	19.9 (17.7 - 22.2)	28.6 (25.4 - 32.1)	11.7 (10.0 - 13.6)
Сүүлийн 30 хоногт хамгийн багадаа нэг өдөр электрон тамхи татсан	24.8 (20.9-29.2)	29.9 (25.5-34.6)	20.0 (15.7-25.2)
Архи, согтууруулах ундааны хэрэглээ			
Сүүлийн 30 хоногт согтууруулах ундааг “НЭГ УУЛТ” хэмжээгээр хамгийн багадаа нэг өдөр хэрэглэсэн	10.8 (8.3 - 14.0)	11.2 (8.2 - 15.1)	10.5 (7.7 - 14.0)
Согтсон байдалд нэг болон түүнээс олон удаа орж байсан	14.5 (12.2-17.2)	16.4 (13.7-19.5)	12.7 (9.8-16.2)
Нөхөн үржихүйн эрүүл мэнд			
Бэлгийн харьцаанд орсон	18.9 (16.4-21.8)	21.7 (17.9-26.1)	16.4 (14.3-18.8)
Сүүлийн бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэсэн	63.9 (55.8-71.3)	70.8 (63.9-76.9)	55.1 (43.3-66.4)
Хамгаалах хүчин зүйлс, сүүлийн нэг сараар			
Нэг ба түүнээс олон өдөр шалтгаангүйгээр хичээлээ тасалсан	26.5 (22.7-30.7)	27.8 (23.8-32.1)	25.2 (20.5-30.7)
Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ сэтгэлийг зовоосон асуудлыг огт ойлгож, дэмждэггүй	57.3 (54.4-60.2)	60.6 (57.1-64.0)	54.5 (49.9-58.9)
Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгааг эцэг эх, асран хамгаалагч нар анхаардаггүй байдал	25.9 (23.4-28.6)	26.1 (23.2-29.2)	25.6 (22.5-28.9)

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ (ЕБС-ийн суралцагчид, хот)

БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАН ҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА, GSHS-2023

Боловсролын орчин дахь хүүхдийн эрүүл мэндийн зан үйлийг тодорхойлох судалгаа, GSHS-2023” судалгааны мэдээлэл цуглуулалтыг ДЭМБ-ын стандарт аргачлалын дагуу 2023 оны 4 дүгээр сарын 17-ноос 5 дугаар сарын 13-ны хооронд үндэсний хэмжээнд зохион байгуулав. Судалгааг 2 шатлалт, санамсаргүй түүврийн аргаар хот, хөдөөгөөс нийт 51 ЕБС-ийн 8-12 дугаар ангийн нийт суралцагчдыг оролцох боломжтойгоор сонгосон. Сонгогдсон ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч нараас судалгаанд оролцох зөвшөөрлийг таниулсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсэгээр баталгаажуулан авсан. Судалгаанд сургуулийн хамрагдалтын түвшин 100%, суралцагчдын хамрагдалт 85.9% байв.

ЕБС-ийн 13-17 насны суралцагчдын дунд	Нийт %, (95% ИХ)	Эрэгтэй %, (95% ИХ)	Эмэгтэй %, (95% ИХ)
Хооллолтын хэв маяг			
Тураалтай суралцагчдын хувь (БЖИ дунджаас <-2СХ)	3.1 (2.3 - 4.0)	3.9 (2.9 - 5.4)	2.2 (1.3 - 3.8)
Илүүдэл жинтэй суралцагчдын хувь (БЖИ-ийн дунджаас >+1СХ)	14.5 (11.3 - 18.5)	14.3 (10.2 - 19.6)	14.7 (11.6 - 18.5)
Таргалалтай суралцагчид (БЖИ-ийн дунджаас >+2СХ)	3.0 (2.0 - 4.5)	3.7 (2.2 - 6.3)	2.3 (1.3 - 4.1)
Сүүлийн 7 хоногт өдөрт нэг ба түүнээс олон удаа чихэрлэг ундаа уусан суралцагчдын хувь	10.2 (8.0 - 13.0)	8.1 (5.8 - 11.3)	11.9 (8.7-16.1)
Эрүүл ахуйн дадал, сүүлийн нэг сараар			
Шүдээ огт угаагаагүй болон өдөрт нэг түүнээс цөөн удаа угаадаг	6.7 (5.0 - 8.9)	8.5 (6.1 - 11.8)	5.1 (3.5 - 7.3)
Ариун цэврийн өрөөнд орсны дараа гараа огт угаадаггүй буюу ховор угаадаг	3.3 (2.0 - 5.5)	3.3 (1.7 - 6.2)	3.0 (1.7 - 5.2)
Осол гэмтэл, хүчирхийлэл, сүүлийн 12 сараар			
Осол, гэмтэлд өртсөн байдал	41.3 (37.1 - 45.6)	43.0 (37.5 - 48.6)	39.6 (33.3 - 46.3)
Бусадтай зодолдсон байдал	27.8 (24.9 - 30.9)	37.2 (33.1 - 41.5)	18.8 (16.0 - 22.1)
Сургуулийн орчинд хүчирхийлэлд өртсөн байдал	26.7 (24.5 - 29.1)	27.5 (24.7 - 30.5)	25.8 (22.1 - 29.9)
Цахим хүчирхийлэлд өртсөн байдал	18.5 (16.7 - 20.4)	14.4 (12.0 - 17.3)	22.1 (19.4 - 24.9)
Сэтгэцийн эрүүл мэнд, сүүлийн 12 сараар			
Дотнын найзгүй суралцагчдын хувь	8.8 (6.8 - 11.3)	7.2 (5.5 - 9.5)	10.3 (7.6 - 14.0)
Амиа хорлох талаар бодож байсан	41.7 (38.0 - 45.4)	30.3 (25.2 - 35.9)	52.3 (47.2 - 57.4)
Амиа хорлох гэж нэг ба түүнээс олон удаа оролдож байсан	16.5 (13.8 - 19.6)	10.1 (7.4 - 13.7)	22.4 (18.4 - 27.0)
Тамхины хэрэглээ			
Сүүлийн 30 хоногт хамгийн багадаа нэг өдөр тамхи татсан	10.9 (8.3 - 14.2)	16.6 (12.7 - 21.5)	5.5 (3.8 - 8.0)

Тамхи татаж үзсэн суралцагчдын хувь	20.0 (17.2 - 23.0)	28.6 (24.4 - 33.2)	12.0 (10.0 - 14.3)
Сүүлийн 30 хоногт хамгийн багадаа нэг өдөр электрон тамхи татсан	27.4 (22.5 - 32.9)	32.8 (27.8 - 38.2)	22.3 (16.7 - 29.1)
Архи, согтууруулах ундааны хэрэглээ			
Сүүлийн 30 хоногт согтууруулах ундааг “НЭГ УУЛТ” хэмжээгээр хамгийн багадаа нэг өдөр хэрэглэсэн	12.0 (8.7 - 16.3)	12.2 (8.3 - 17.4)	11.8 (8.2 - 16.6)
Согтсон байдалд нэг болон түүнээс олон удаа орж байсан	15.3 (12.3 - 18.9)	17.0 (13.6 - 20.9)	13.6 (9.9 - 18.4)
Нөхөн үржихүйн эрүүл мэнд			
Бэлгийн харьцаанд орсон	19.5 (16.2 - 23.3)	22.4 (17.5 - 28.2)	17.0 (14.3 - 20.0)
Сүүлийн бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэсэн	63.2 (52.7 - 72.5)	-	-
Хамгаалах хүчин зүйлс, сүүлийн нэг сараар			
Нэг ба түүнээс олон өдөр шалтгаангүйгээр хичээлээ тасалсан	24.9 (20.1 - 30.4)	25.1 (20.4 - 30.5)	24.7 (18.6 - 32.0)
Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ сэтгэлийг зовоосон асуудлыг огт ойлгож, дэмждэггүй	57.1 (52.9 - 61.3)	60.6 (56.0 - 65.0)	54.1 (47.5 - 60.6)
Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгааг эцэг эх, асран хамгаалагч нар анхаардаггүй байдал	24.3 (21.0 - 28.0)	25.4 (21.5 - 29.8)	23.1 (19.1 - 27.7)

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ (ЕБС-ийн суралцагчид, хөдөө)

БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАН ҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА, GSHS-2023

Боловсролын орчин дахь хүүхдийн эрүүл мэндийн зан үйлийг тодорхойлох судалгаа, GSHS-2023” судалгааны мэдээлэл цуглуулалтыг ДЭМБ-ын стандарт аргачлалын дагуу 2023 оны 4 дүгээр сарын 17-ноос 5 дугаар сарын 13-ны хооронд үндэсний хэмжээнд зохион байгуулав. Судалгааг 2 шатлалт, санамсаргүй түүврийн аргаар хот, хөдөөгөөс нийт 51 ЕБС-ийн 8-12 дугаар ангийн нийт суралцагчдыг оролцох боломжтойгоор сонгосон. Сонгогдсон ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч нараас судалгаанд оролцох зөвшөөрлийг таниулсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсэгээр баталгаажуулан авсан. Судалгаанд сургуулийн хамрагдалтын түвшин 100%, суралцагчдын хамрагдалт 85.9% байв.

ЕБС-ийн 13-17 насны суралцагчдын дунд	Нийт %, (95% ИХ)	Эрэгтэй %, (95% ИХ)	Эмэгтэй %, (95% ИХ)
Хооллолтын хэв маяг			
Тураалтай суралцагчдын хувь (БЖИ дунджаас <-2СХ)	3.8 (1.5 - 9.6)	5.0 (2.0 - 11.8)	2.7 (0.9 - 7.8)
Илүүдэл жинтэй суралцагчдын хувь (БЖИ-ийн дунджаас >+1СХ)	15.0 (12.5 - 18.0)	11.0 (8.5 - 14.1)	19.0 (15.0 - 23.6)
Таргалалтай суралцагчид (БЖИ-ийн дунджаас >+2СХ)	3.1 (1.9 - 5.0)	3.0 (1.5 - 6.0)	3.2 (2.0 - 5.0)
Сүүлийн 7 хоногт өдөрт нэг ба түүнээс олон удаа чихэрлэг ундаа уусан суралцагчдын хувь	9.0 (6.9 - 11.5)	8.9 (6.1 - 12.9)	8.9 (6.8 - 11.7)
Эрүүл ахуйн дадал, сүүлийн нэг сараар			
Шүдээ огт угаагаагүй болон өдөрт нэг түүнээс цөөн удаа угаадаг	5.3 (4.3 - 6.6)	7.4 (5.1 - 10.5)	3.3 (2.3 - 4.9)
Ариун цэврийн өрөөнд орсны дараа гараа огт угаадаггүй буюу ховор угаадаг	7.3 (5.1 - 10.4)	7.0 (4.4 - 10.9)	7.5 (5.1 - 11.0)
Осол гэмтэл, хүчирхийлэл, сүүлийн нэг жилээр			
Осол, гэмтэлд өртсөн байдал	33.9 (29.5 - 38.7)	38.0 (33.5 - 42.8)	29.9 (24.6 - 35.9)
Бусадтай зодолдсон байдал	29.5 (26.3 - 32.8)	38.8 (34.8 - 42.8)	20.5 (16.6 - 25.1)
Сургуулийн орчинд хүчирхийлэлд өртсөн байдал	27.3 (25.1 - 29.6)	31.7 (27.4 - 36.4)	22.9 (20.1 - 26.1)
Цахим хүчирхийлэлд өртсөн байдал	15.6 (13.3 - 18.3)	13.3 (10.2 - 17.1)	18.0 (14.0 - 22.7)
Сэтгэцийн эрүүл мэнд, сүүлийн 1 жилээр			
Дотнын найзгүй суралцагчдын хувь	6.7 (5.1 - 8.8)	5.1 (3.7 - 7.0)	8.3 (5.8 - 11.8)
Амиа хорлох талаар бодож байсан	29.5 (26.2 - 33.1)	21.6 (17.4 - 26.4)	37.3 (32.0 - 43.1)
Амиа хорлох гэж нэг ба түүнээс олон удаа оролдож байсан	12.9 (10.1 - 16.3)	9.8 (6.3 - 15.0)	15.7 (13.3 - 18.6)



Тамхины хэрэглээ			
Сүүлийн 30 хоногт хамгийн багадаа нэг өдөр тамхи татсан	12.2 (9.6 - 15.4)	20.5 (16.4 - 25.3)	4.2 (3.0 - 5.9)
Тамхи татаж үзсэн суралцагчдын хувь	20.2 (16.6 - 24.2)	30.7 (26.4 - 35.5)	9.9 (6.8 - 14.2)
Сүүлийн 30 хоногт хамгийн багадаа нэг өдөр электрон тамхи татсан	16.5 (11.6 - 22.9)	22.0 (14.8 - 31.3)	11.3 (7.5 - 16.6)
Архи, согтууруулах ундааны хэрэглээ			
Сүүлийн 30 хоногт согтууруулах ундааг "НЭГ УУЛТ" хэмжээгээр хамгийн багадаа нэг өдөр хэрэглэсэн	6.7 (4.8 - 9.1)	7.8 (5.3 - 11.4)	5.5 (3.3 - 9.0)
Согтсон байдалд нэг болон түүнээс олон удаа орж байсан	11.7 (8.5 - 15.8)	15.0 (10.4 - 21.1)	8.5 (5.5 - 12.9)
Нөхөн үржихүйн эрүүл мэнд			
Бэлгийн харьцаанд орсон	16.6 (13.5 - 20.2)	19.3 (14.9 - 24.6)	14.0 (10.6 - 18.3)
Сүүлийн бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэсэн	70.1 (62.2 - 76.9)	-	-
Хамгаалах хүчин зүйлс, сүүлийн нэг сараар			
Нэг ба түүнээс олон өдөр шалтгаангүйгээр хичээлээ тасалсан	32.2 (29.3 - 35.3)	37.5 (32.1 - 43.2)	27.2 (23.6 - 31.1)
Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ сэтгэлийг зовоосон асуудлыг огт ойлгож, дэмждэггүй	57.0 (54.0 - 60.0)	59.5 (54.9 - 63.8)	54.7 (51.1 - 58.4)
Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгааг эцэг эх, асран хамгаалагч нар анхаардаггүй байдал	30.7 (27.7 - 33.8)	28.0 (23.9 - 32.6)	33.4 (30.5 - 36.4)



БҮЛЭГ 1. ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

1.1 ОРШИЛ

ДЭМБ, НҮБ-ын ДОХ-ын Хөтөлбөр, НҮБ-ын БСШУТ, НҮБХС, АНУ-ын ӨХСТ-ийн техник, хамтын ажиллагааны тусламжтайгаар 2001 онд дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа (ДДССЭМС)-ны арга зүйг боловсруулсан [1]. 2003 оноос энэхүү нэгдсэн аргачлалаар Дэлхийн улс орнууд засгийн газар, эрүүл мэнд болон боловсролын байгууллагаар дамжуулан өөрийн орны оюутан, сурагчдын эрүүл мэндийн зан үйлийн эрсдэл болон хамгаалах хүчин зүйлсийн тархалтыг тогтоох, хянах зорилгоор тус судалгааг үе шаттай явуулж, судалгааны үр дүнг үндэслэн бодлого, шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

Монгол улс 2010, 2013 онуудад сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгааг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн (хуучин нэрээр) нь мэргэжил арга зүйгээр удирдан бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран үндэсний хэмжээнд 2 удаа амжилттай зохион байгуулсан.

Өсвөр насны хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн өнөөгийн байдлыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилт, ДЭМБ-ын техникийн дэмжлэгтэйгээр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгүүдтэй хамтран “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн судалгаа”-г 2022-2023 онд хийж, гүйцэтгэлээ.

Судалгааны арга, аргачлалыг НЭМҮТ-ийн дэргэдэх Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, батлуулж, ЭМЯ-ны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо болон Үндэсний статистикийн хорооны Арга зүйн байнгын зөвлөл болон Даргын зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлж, үндэсний хэмжээнд судалгаа хийх зөвшөөрөл авсан. “Тогтвортой хөгжлийн Дэлхийн зорилт-2030”, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгагдсан 17 зорилго бүрийг бодлогоор салбар хооронд нягт уялдуулсан байдаг. Иймээс энэхүү судалгааг өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх суурь мэдээлэл, нотолгоо бий болгох зорилгоор хийж гүйцэтгэлээ.

1.2 ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЭРҮҮЛ МЭНД ДЭЛХИЙ ДАХИНД

Өнөө үед ХБӨ-ий тархалт хурдацтай нэмэгдэж, хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааныг тэргүүлж, дэлхий дахины тулгамдсан асуудлын нэг хэвээр байна [2]. ХБӨ нь хүний амьдралын буруу хэв маяг, зан үйлээс үүдэлтэй бөгөөд сэргийлэх боломжтой эрсдэлт хүчин зүйлстэй холбоотой болохыг эрдэмтэд судлан тогтоосон. Энэ нь өсвөр насны хүүхдийн хувьд ч адилхан бөгөөд хүүхэд насанд тогтсон муу зан үйл, буруу хэв маяг нь насанд хүрсэн үед ч хадгалагдсаар байдаг байна.

Дэлхий дээр 13-15 насны 10 хүүхэд тутмын 1 нь өсвөр насандаа тамхи татаж эхэлсэн байна [2]. 2023 онд АНУ-ын ӨХСТ-өөс хийсэн судалгаагаар ахлах ангийн суралцагчдын 10.0%, дунд ангийн суралцагчдын 4.6% сүүлийн нэг сард электрон тамхи татсан гэсэн тоон үзүүлэлт гарсан байна [3].

Жил бүр 3 сая хүн архи, согтууруулах ундааны хор уршгаас болж нас барж байгаа нь нийт нас баралтын 5.3%-ийг эзэлж байна [2].

2023 онд ДЭМБ-ын мэдээлсэнээр 155 сая гаруй 15-19 насны хүүхдүүд архи, согтууруулах ундаа хэрэглэдэг бөгөөд үүний 13.6% нь архийг хэтрүүлэн хэрэглэж байна [2].

2018 оны байдлаар 15-16 насны хүүхдүүдийн 4.7% нь сэтгэцэд нөлөөлөх мансууруулах төрлийн бодисыг хамгийн багадаа нэг удаа хэрэглэж үзсэн байна. Өсвөр насныхны дунд сэтгэл гутрал, зан төлөвийн өөрчлөлт, амиа хорлох хандлага зэрэг сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой асуудал нь ихэвчлэн 14 наснаас эхэлдэг байна [2].

Бэлгийн харьцаанд эрт орох нь эрт жирэмслэлт, ХДХВ болон БЗДХ-аар өвчлөх эрсдэл болдог. 2019 оны судалгаагаар бага болон дунд орлоготой улс орнуудын 15-19 насны 21 сая өсвөр насны охид жирэмсэлсэн ба үүний 12 сая гаруй нь хүүхдээ эсэн мэнд төрүүлсэн байна. Өсвөр

насны охидод төрсний дараах сэтгэл гутрал 25 настай эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2 дахин их тохиолддог ба амиа хорлох эрсдэл энэ насны ээж болоогүй охидтой харьцуулахад илүү их байгааг судалгаагаар тогтоожээ [2].

2016 онд хийгдсэн судалгаагаар 10-19 насны 6 хүүхэд тутмын 1 нь илүүдэл жинтэй байна. Энэ үзүүлэлт нь охидод 18.0% харин хөвгүүдэд 19.0% байна. Өсвөр насны хүүхдийн илүүдэл жин таргалалт нь 1975 оноос хойш тасралтгүй нэмэгдсээр байна [2].

1.3 МОНГОЛ УЛСЫН ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЭРҮҮЛ МЭНД

Монгол улсын хүн ам 2022 онд 3 сая 457.5 мянга болж, өмнөх оныхоос 47.6 мянган хүн буюу 1.4%-иар өссөн байна. Нийт хүн амын 16.6%-ийг 10-19 насныхан буюу өсвөр үеийнхэн эзэлж байна [4].

Сүүлийн жилүүдэд хүн амын дунд цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдрын шалтгаант нас баралт нэмэгдсээр байна. 2022 онд 6885 хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэн ба элэгний хорт хавдар 33.2%, ходоодны хорт хавдар 17.1%, уушги гуурсан хоолой хорт хавдар 7.6%, улаан хоолой 5.0%, умайн хүзүүний хорт хавдар 4.6% эзэлж байгаа ба нийт хорт хавдрын 67.5%-ийг дээрх хорт хавдрууд эзэлж байна. 2022 онд хорт хавдрын өвчлөлийн улмаас 26347 хүн хяналтад байгаагийн 525 нь 0-19 (2.0%) насны хүүхдүүд байна [5].

Насанд хүрэгчдийн нас баралтын шалтгаан нь өсвөр наснаас тогтсон зан үйлийн нөлөө нь тодорхой байр суурийг эзэлдэг болохыг эрдэмтэд баталсан. Осол гэмтэл, амиа хорлолт, хүчирхийлэл болон жирэмслэлттэй холбоотой гарах хүндрэл болон бусад өвчлөл эндэгдэл өсвөр насныхны дунд түгээмэл хэвээрээ байна. Тухалбал, 10-14 насны хүүхдүүдийн дунд төрөл бүрийн хэлбэрээр амиа хорлох үйлдлийн хувь 2013 оноос хойш 5 дахин нэмэгдсэн бол 2022 онд нас барсан 15-19 насныхны 23.9% буюу мөн 4 хүүхэд тутмын 1 нь амиа хорлон нас барсан байна [6]. 2017 онд бүртгэгдсэн бэлгийн замын халдварт өвчний нийтлэг тохиолдлын 39.0%-ийг 15-24 насны залуучууд эзэлж байсан [6]. 2013 онд хийсэн судалгааны дүнгээс харахад [8]:

Хүнс, хоолны хэрэглээ. Өсвөр насны хүүхдийн 10.6% нь илүүдэл жинтэй, 1.5% нь таргалалттай. 5 сурагч тутмын 1 нь жимс ногоог зохистой хооллолтын зөвлөмжийн дагуу өдөрт 5 ба түүнээс олон удаа хэрэглэдэг. Хийжүүлсэн, чихэрлэг ундаа болон түргэн хоолны газар, сургуулийн цайны газраар тогтмол үйлчлүүлдэг суралцагчид 33.6%-тай байна.

Архи, тамхи. Судалгаагаар нийт суралцагчдын 10 орчим хувь нь тамхи татдаг болохыг тогтоожээ. 4 хүүхэд тутмын 1 нь согтууруулах төрлийн ундаа хэрэглэж үзсэн, сүүлийн нэг сарын хугацаанд суралцагчдын 8.9% нь согтууруулах төрлийн удааг хэрэглэж үзсэн байна.

Бэлгийн зан үйл. Нийт суралцагчдын 15.3% нь бэлгийн харьцаанд орсон. Бэлгийн харьцаанд орсон суралцагчдын дийлэнх нь сүүлийн бэлгийн харьцааны үед бэлгэвч хэрэглээгүй ба 2 болон түүнээс дээш хүнтэй бэлгийн харьцаанд орсон байна. Энэ нь БЗДХ авах эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Сэтгэцийн эрүүл мэнд ба мансууруулах бодисын хэрэглээ. 4 суралцагч тутмын 1 нь сүүлийн жилд амиа хорлох талаар бодож, 7 суралцагчийн 1 нь амиа хорлохоор төлөвлөж, 10 суралцагчийн 1 нь нэг ба түүнээс олон удаа амиа хорлох оролдлого хийсэн. 9 суралцагчийн 1 нь мансууруулах төрлийн бодис хэрэглэж үзсэн ба энэ үзүүлэлт нь эрэгтэй суралцагчдын дунд илүү байна.



1.4 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Энэхүү судалгааг боловсролын орчин дахь хүүхдийн эрүүл мэндийн зан үйл, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшинг тогтоох зорилгоор дараах зорилтуудын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. Боловсролын орчин дахь суралцагчдын өсөлт, хоол тэжээлийн байдалд үнэлгээ өгөх
2. Боловсролын орчин дахь суралцагчдын эрүүл мэндийн зан үйлийн эрсдэлт хүчин зүйл болон хамгаалах хүчин зүйлсийг тодорхойлох
3. Боловсролын орчин дахь суралцагчдын эрүүл зан үйлийг сайжруулах, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх бодлого, шийдвэрт нотолгоо бүрдүүлэх

1.5 СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ

Энэхүү судалгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын эрүүл мэндийн зан үйлтэй холбоотой асуудлаар тоон мэдээллийг бий болгох, түүнд нөлөөлөхүйц хүчин зүйлсийн цар хүрээ, хэлбэрийг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний суурь мэдээллийн баазыг бүрдүүлж байгаагаараа чухал ач холбогдолтой юм. Цаашид суралцагчдад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх, Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, олон улсын болон хөрш зэргэлдээ орнуудын өсвөр үе, оюутан сурагчдын энэ чиглэлээр хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулахад суурь мэдээлэл болох ач холбогдолтой.

1.6 СУДАЛГААНЫ БАЙДАЛ

Хүүхдийн эрүүл мэнд, эрх, хамгааллын асуудлаар сүүлийн 10 жилийн хугацаанд манай улсад дараах судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн байна. Үүнд:

Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа, 2010, 2013 он

Эрүүл мэндийн яам, ДЭМБ-тай хамтран Монгол Улсын хэмжээнд 13-17 насны хүүхдүүдийн хүнс, хоолны хэрэглээ, дасгал хөдөлгөөн, тамхи, согтууруулах ундааны хэрэглээ, үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл, хамгаалал зэрэг 10 модулийн хүрээнд хүүхдийн эрүүл зан үйл, аюулгүй байдлыг судалсан [7, 8].

Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа, 2014 он

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар нь нийслэлийн хэмжээнд 11-17 насны хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдийн хүрээнд хүүхэд хүчирхийлэлд өртөж буй байдлыг бие махбодын, сэтгэл зүйн, бэлгийн хүчирхийллийн гэсэн хэлбэрүүдээр ангилан судалсан [9].

Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал, 2015 он

Хөгжлийн санаачлага, бодлого судлалын төв, МУИС хамтран хүүхдийг дарамт, үл хайхрал ба мөлжлөгөөс хамгаалах, урьдчилсан сэргийлэх хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх, тарийн байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээг бэхжүүлэх, орон нутаг дахь анхан шатны нэгжийн хүүхэд хамгааллын механизмд дэмжлэг үзүүлэх, олон нийтэд хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр судалгааг гүйцэтгэсэн [10].

Хүүхдийн эрх ба хамгаалал судалгаа, 2017 он

Хүний эрхийн Үндэсний Комисс, “Гүүд Нэйборс” олон улсын байгууллага хамтран хүүхдийн эрхийн зөрчил, түүний шалтгаан, хүүхэд хамгааллын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэсэн. Хүүхдийн эрхийн зөрчлийн судалгааны үр дүнгээс харахад хүүхдийг үл хайхрах, хүүхдийг хүмүүжүүлэх нэрээр хүчирхийлэх хандлага нэмэгдэж байгаа нь зайлшгүй анхаарах асуудал болоод байна [11].

Өсвөр үеийнхний дуу хоолой-2, 2018 он



Хүүхдийг ивээх сан, өсвөр үеийн төлөөлөл болон Транспаренси Интернэйшнл байгууллагууд хамтран боловсролын болон гэр бүлийн орчин мөн өнөөгийн нийгэм хүүхдүүдийн шударга ёс, цаашлаад тэдний хувь хүн төлөвшилтөд хэрхэн нөлөөлж байгаа талаар судалсан [12].

Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийн судалгаа, 2018 он

БСШУЯ-аас 2-21 насны хүүхэд, залуучуудын дунд бие бялдар, танин мэдэхүйн болон нийгэмшлийн хөгжлийн онцлогийг насны бүлэг бүрээр харьцуулан судалсан [13].

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он

Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулдаг энэхүү судалгааны “Хүүхдийн хүмүүжил” бүлэгт 1-14 насны хүүхдийн хүмүүжлийн үед тэдэнд тулгардаг бие махбод болон сэтгэл санааны хүчирхийллийн талаар судалжээ [14].

Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийг зогсоох нь, 2019 он

ЮНЕСКО-гоос нийт 144 орныг хамруулсан сургуулийн орчин дахь дээрэнгүйлэлт, хүчирхийллийн талаарх дэлхийн болон бүс нутаг дахь тархалт, хандлага, улс орнуудын хариу арга хэмжээнд дүн шинжилгээ хийсэн байна [15].

Хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн асуудлын судалгаа, 2021 он

НҮБ-ын Хүүхдийн Сангаас хэрэгжүүлсэн энэхүү судалгаагаар коронавируст халдварын тархалттай холбоотойгоор тогтоосон хөл хорионы үед хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор хүүхэд, эцэг эх, багш нарт тулгамдсан асуудлыг судлан, тогтоож, тэдний сэтгэлзүйд гарч болзошгүй эрсдэлийг судалсан [16].

Монгол улсын хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал, 2021 он

Монгол улсын Засгийн газар АНУ-ын Төрийн департаменттэй хамтран хэрэгжүүлсэн “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ”-ний дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн Зөн Монгол ОУБ хамтран манай улсын хүүхэд хамгааллын өнөөгийн байдлыг эрх зүйн орчин, үйлчилгээ, чадавх, хамтын ажиллагаа, хариуцлагатай байдал, хүүхэд хамгааллын үйлчилгээний механизм, хүүхдийн амьдрах ухаан, оролцоо зэргийг судлан тогтоосон байна [17].

Өсвөр үеийнхний эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх асуудал, 2018-2021 он

Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр ЭМЯ-ны захиалгаар гүйцэтгэсэн энэхүү судалгаа нь өсвөр үеийнхний дунд зонхилон тохиолдож буй эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг судлан, тогтоож, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрсдлийг бууруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмж боловсруулсан. Ингэснээр шийдвэр гаргах түвшинд шинжлэх ухааны үндэслэлтэй нотолгоо бий болгож чадсан гэж үзэж болно [18].



БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.1. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгаанд улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд суралцаж байсан 773 Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн нийт 237521 суралцагчид эх олонлогийг бүрдүүлсэн. Эх олонлогоос түүвэрлэн авсан хэсгээр төлөөлүүлэн хот, хөдөөгөөс сонгогдсон сургуулиудын 8-12 дугаар ангийн бүх суралцагчдийг хамруулан, үндэсний түвшинд, нэг агшингийн судалгааг гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнг үндэсний болон хот, хөдөөд хүлээн зөвшөөрөгдөхүйц байхаар тооцсон.

2.2. ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ, ТҮҮВЭРЛЭЛТ

Тус судалгааг 2 шатлалт, санамсаргүй түүврийн аргаар хотын 26, хөдөөгийн 25 ЕБС-ийн нийт 3857 хүүхэд судалгаанд оролцох боломжтойгоор сонгосноос сургуулийн хамрагдалт 100%, суралцагчдын хамрагдалт 85.9%-тай байж, нийт 3311 суралцагч хамрагдсан.

Сургуулийн түвшинд: Эхний шатны түүвэрлэлтийг Жөнөв дэх ДЭМБ-ын ХБӨ-ний асуудал хариуцсан албаны Тандалт, хяналт, тайлагналтын нэгжийн судалгааны түүвэрлэлтийн асуудал эрхэлсэн баг хийж, стандарт аргачлалын дагуу 8-12 дугаар ангийн 51 сургууль пропорциональ магадлалаар сонгогдсон.

Ангийн түвшинд: Дараагийн шатанд сонгогдсон аймаг, нийслэлийн ЕБС-ийн нийт анги, бүлэг, хүүхдийн тоонд үндэслэн санамсаргүй түүврийн аргаар судалгаанд оролцох анги, бүлгийг сонгосон. Сонгогдсон ангиуд нь бүгд түүврийн хэмжээнд багтсан бөгөөд тухайн ангийн нийт сурагчдад судалгаанд оролцох эрхтэй байхаар боломжийг бүрдүүлсэн.

2.3. СУДАЛГААНЫ АСУУМЖ

Судалгааны асуумж нь дараах 9 бүлэг бүхий нийт 74 асуултаас (хавсралт 1) бүрдсэн.

1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд
2. Хүнс, хоолны хэрэглээ
3. Эрүүл ахуйн дадал
4. Осол гэмтэл, хүчирхийлэл
5. Сэтгэцийн эрүүл мэнд
6. Тамхины хэрэглээ
7. Архины хэрэглээ
8. Хамгаалах хүчин зүйлс
9. Бэлгийн зан үйл

Судалгааны асуумж нь ДЭМБ, НҮБХС, НҮББСШУТ, АНУ-ын ӨХСТ-ийн мэргэжилтнүүдийн хамтран боловсруулсан Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаанд ашиглагддаг, Дэлхийн НДББ-ийн нийт 104 улс оронд хийгдсэн 10 модуль асуумжийг үндэслэн манай орны нөхцөлд тохирох байдлаар шинэчлэн боловсруулсан асуулгаас бүрдсэн.

Суралцагчдын бие бялдрын хэмжилт:

- Биеийн жин
- Биеийн өндөр

Бие бялдрын үзүүлэлтийг тооцохдоо суралцагчдын жин, өндрийн үзүүлэлтийг ашигласан.

Биеийн жин: “ТАНИТА BC-587” электрон жинг ашиглан судалгаанд оролцогчийн биеийн жинг хэмжсэн. (Электрон жин нь эрдэм шинжилгээ, судалгааны ажилд ашиглах зориулалттай, 100 000 удаа хэмжилт хийх нөөц бүхий лити батарейтай, 100 граммын нарийвчлалаар 200 кг хүртэлх жинг хэмжих боломжтой)

Биеийн өндөр: “IN LAB S50” багаж ашиглан оролцогчдын биеийн өндрийг тодорхойлов. (Өндөр хэмжигч нь 2 метр хүртэлх өндрийг хэмжих боломжтой, хэмжилтийн заалтыг миллиметрийн нарийвчлалтайгаар, сантиметрээр илэрхийлсэн).

2.4. МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ, ЖИНЛЭЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгаагаар цуглуулсан хариулгын хуудсыг ДЭМБ-ын Номхон Далайн Баруун бүсээс шуудангаар битүүмжлэлтэйгээр илгээж тусгай зориулалтын скайнер машинд уншуулан, компьютерт оруулсан. Энэхүү уншуулах үйл ажиллагааг Женев дэх ДЭМБ-ын Халдварт бус өвчний сэргийлэлтийн асуудал хариуцсан албаны, Тандалт, хяналт, тайлагналтын нэгжийн судлаач, мэргэжилтнүүд гүйцэтгэж, тоон мэдээллийг кодолсон. Судалгааны үр дүнг тооцож, хүснэгтлэн боловсруулахдаа ДЭМБ-ын стандарт удирдамж, шалгуур үзүүлэлтийн дагуу байршил, хүйс, анги, насны бүлгээр харьцуулан гаргасан ба ДЭМБ-аас боловсруулсан “Судалгааны үндсэн үр дүнгийн хураангуй”, “Судалгааны үр дүнгийн эмхэтгэл” боловсруулах зааврыг ашигласан.

Судалгааны үр дүн 95%-ийн магадлалтай, алдааны хязгаар 5%-аас хэтрэхгүй байхаар түүврийн хэмжээг тогтоосон. Судалгааны зарим үзүүлэлтийг статистикийн багц программ ашиглан тооцсон. Олон шатлалт кластер түүвэрлэлтийн аргаар судалгааны нэгжийг сонгосон тохиолдолд статистик боловсруулалтын үр дүнг зайлшгүй жинлэх шаардлагатай байдаг.

Жинлэлт нь сурагч бүрийн сонгогдох магадлалыг тусгах, хариултгүй асуулт жинлэлтэд нөлөөлөх нөлөөллийг багасгахын тулд асуумж бүртэй холбоотой байсан. Жинлэлтийг тооцохдоо:

$$W=W1*W2*f1*f2*f3$$

W1= тухайн сургууль сонголтын урвуу магадлал

W2= сонгогдсон сургуулийн анги сонголтын урвуу магадлал

f1= сургуулийн түвшинд хариулт өгөөгүй тохируулгын коэффициент нь сургуулийн хэмжээгээр буюу асуулгын хамрагдалтаар тодорхойлогдоно

f2= суралцагчдын түвшинд хариулт өгөөгүй тохируулгын коэффициент нь ангиар тооцогдоно

f3= сурагчдыг ангиар нь бүлэглэсэн тохируулгын коэффициент

Жинлэсэн үр дүн нь Монгол улсын ЕБС-ийн 8-12 дугаар ангийн бүх суралцагчдын эрүүл мэндийн зан үйлийн эрсдэл болон хамгаалах хүчин зүйлстэй холбоотой мэдээллийг төлөөлсөн.

2.5. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙН СУРГАЛТ

Энэхүү үндэсний судалгаа хийх арга зүйн сургалтыг 2 үе шатлалтайгаар зохион байгуулсан. Эхний сургалтыг Женев дэх ДЭМБ-ын Халдварт бус өвчний асуудал хариуцсан албаны Тандалт, хяналт, тайлагналтын нэгжийн Зөвлөх Лоура Кэннийн удирдлагаар, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран 2022 оны 12 дугаар сарын 16-17 өдрүүдэд цахим хэлбэрээр судлаачдад зохион байгуулсан. Мөн 2023 оны 4 дүгээр сарын 10-15-ны өдрүүдэд мэдээлэл цуглуулагч, мэдээлэл шивэгч нарт батлагдсан хөтөлбөрийн дагуу танхимын сургалтыг зохион байгуулсан. Сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгааны талаарх бусад улс орнуудад хийгдэж буй туршлага, танилцуулга болон сонгогдсон сургуульд судалгааг зохион байгуулах, түүвэрлэлт хийх, асуумж судалгааг авах, хариултын хуудсыг шалгаж авах, суралцагчдын биеийн жин, өндрийг хэмжих, судлаачийн ёс зүй, багийн ахлагч болон гишүүдийн эрх, үүрэг, судалгаатай холбоотой бусад хуудсуудыг бөглөх талаар нэгдсэн аргачлалд бүх судлаачдыг сургасан. Нийслэлийн Ерөнхий боловсролын лаборатори 23, 155 дугаар сургууль болон Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулиудыг түшиглэн судалгааны бүхий л үе шатыг хамруулсан туршилтын судалгааг 5 хоногийн турш газар дээр нь зохион байгуулсан.

2.6. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Судалгааг 2023 оны 4 дүгээр сарын 17-ноос 5 дугаар сарын 13-ны хооронд сонгогдсон аймаг, дүүргийн ЕБС-уудад үндэсний түвшинд гүйцэтгэсэн. Судалгааны баг нь багийн ахлагч болон үндсэн



3 судлаачийн бүрэлдэхүүнтэй нийт 4 багийн 16 судлаач талбарт ажилласан ба сонгогдсон орон нутгийн туслах мэргэжилтнүүдтэй хамтран судалгааны мэдээллийг цуглуулсан. Санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон ангид суралцаж буй суралцагчдын эцэг, эх, асран хамгаалагч нарт судалгааны талаарх мэдээллийг сургуулийн багш, нийгмийн ажилтны тусламжтайгаар урьдчилан хүргүүлсэн. Судалгаанд сайн дурын үндсэн дээр оролцох байсан тул эцэг эх, асран хамгаалагчдын зөвшөөрлийг таниулсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулан баталгаажуулсан. Судалгаанд оролцохоор зөвшөөрсөн суралцагчдаас асуулга болон антропометрийн хэмжилтийн арга ашиглан мэдээллийг цуглуулсан. Мэдээлэл цуглуулах явцад судалгааны багуудын үйл ажиллагаанд хяналт хийх, зөвлөн туслах ажлыг судалгааны удирдагч, зөвлөхүүд хариуцан зохион байгуулсан.

2.7. СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН АСУУДАЛ

Судалгааны арга, аргачлалыг НЭМҮТ-ийн дэргэдэх Эрдмийн зөвлөлийн 2022 оны 12 сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. ЭМЯ-ны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар судалгааны аргачлал, түүнтэй холбогдох материалыг хянан хэлэлцэж, судалгааг зохион байгуулах дүгнэлт, зөвшөөрөл авсан. Судалгааны үзэл баримтлал, асуулга, түүнийг нөхөх заавар, түүвэрлэлт зохиомж зэргийг Үндэсний статистикийн хорооны Арга зүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг 01/278 тоот албан бичгээр авч судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах зөвшөөрөл авсан.

2.8. СУДАЛГААНААС ХАСАХ БОЛОН СУДАЛГААНД ХАМРУУЛАХ ШАЛГУУР

Сонгогдсон тухайн сургуулиас санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 8-12 дугаар ангид сурч байгаа бүх суралцагчид судалгаанд оролцох үндсэн шалгуурт багтаж байв. Суралцагчдын эцэг, эх, асран хамгаалагч нар судалгаанд оролцох зөвшөөрлийг таниулсан зөвшөөрлийн хуудсаар өгсөн бүх суралцагчдыг хамруулсан. Эцэг эх, асран хамгаалагч нар нь судалгаанд хамруулахаас татгалзсан, суралцагч өөрөө судалгаанаас татгалзсан, монгол хэлээр уншиж, ойлгох чадваргүй болон оюуны хомсдолтой суралцагчдыг судалгаанд хамруулаагүй болно.

2.9. СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Судалгаанд ЕБС-д өдрөөр суралцаж буй 8-12 дугаар ангийн суралцагчид хамрагдсан бөгөөд оройн ангид болон зайнаас суралцаж буй суралцагчид хамрагдах боломжгүй байв.

Хувийн хэвшлийн сургуульд суралцаж буй суралцагчдын анги дүүргэлт хангалтгүй байсан тул улсын болон хувийн хэвшлийн сургуулийн үр дүнг харьцуулах боломжгүй байлаа.

БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1. ХҮН АМ ЗҮЙ

Судалгаанд хотын 26, хөдөөгийн 25 төрийн болон хувийн ЕБС-ийн 8-12 дугаар ангийн нийт 3311 суралцагч хамрагдсаны 47.9% нь эрэгтэй, 52.1% нь эмэгтэй байлаа. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан суралцагчдын хувь, нас, хүйсээр

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	Бодит тоо	%	Бодит тоо	%	Бодит тоо	%
12 ба түүнээс доош	34	0.8	9	0.5	18	0.7
13-15	2134	60.5	997	62.2	1126	59.0
16-17	952	31.6	437	31.5	514	32.1
18 ба дээш	182	7.0	67	5.8	114	8.3
13-17	3086	92.1	1434	93.7	1640	91.1
Нийт	3311	100	1514	47.9	1774	52.1

Судалгаанд хамрагдсан суралцагчдын хүйсийн харьцаа өмнөх судалгааны дүнгүүдтэй ойролцоо үзүүлэлттэй (2010 онд эрэгтэй 47.5%, 2013 онд эрэгтэй 48.3%, 2023 онд 47.9%) байна.

Нас, болон ангийн хувьд 13-15 насныхан (60.5%), 8-10 дугаар ангийн суралцагчид (71.8%) дийлэнх хувийг эзэлж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан суралцагчдын хувь, хүйс, ангиар

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	Бодит тоо	%	Бодит тоо	%	Бодит тоо	%
8-р анги	1101	27.3	534	28.9	556	25.6
9-р анги	741	25.2	359	26.6	387	23.9
10-р анги	723	19.3	306	18.5	415	20.2
11-р анги	417	15.1	184	14.3	231	15.7
12-р анги	310	13.1	122	11.7	187	14.5
Нийт	3311	100	1514	47.9	1774	52.1

Суралцагчдын дундах халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс

Суралцагчдын дундах халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг дор дурьдсан 23 үзүүлэлтээр авч үзлээ. Үүнд:

Хооллох хэв маяг:

- Тураалт
- Илүүдэл жин
- Таргалалт
- Сүүлийн 7 хоногт өдөрт нэг ба түүнээс олон удаа чихэрлэг ундаа уусан

Эрүүл ахуйн дадал:

- Шүдээ огт угаагаагүй болон өдөрт нэг түүнээс цөөн удаа угаадаг
- Ариун цэврийн өрөөнд орсны дараа гараа огт угаадаггүй буюу ховор угаадаг

Осол гэмтэл, хүчирхийлэл:

- Осол, гэмтэлд өртсөн байдал
- Бусадтай зодолдсон байдал
- Сургуулийн орчинд хүчирхийлэлд өртсөн байдал
- Цахим хүчирхийлэлд өртсөн байдал



Сэтгэцийн эрүүл мэнд:

- Дотнын найзгүй
- Амиа хорлох талаар бодож байсан
- Амиа хорлох гэж нэг ба түүнээс олон удаа оролдож байсан

Тамхины хэрэглээ:

- Сүүлийн 30 хоногт хамгийн багадаа нэг өдөр тамхи татсан
- Тамхи татаж үзсэн
- Сүүлийн 30 хоногт хамгийн багадаа нэг өдөр электрон тамхи татсан

Архи, согтууруулах ундааны хэрэглээ:

- Сүүлийн 30 хоногт согтууруулах ундааг “НЭГ УУЛТ” хэмжээгээр хамгийн багадаа нэг өдөр хэрэглэсэн
- Согтсон байдалд нэг болон түүнээс олон удаа орж байсан

Нөхөн үржихүйн эрүүл мэнд:

- Бэлгийн харьцаанд орсон
- Сүүлийн бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэсэн

Хамгаалах хүчин зүйлс:

- Нэг ба түүнээс олон өдөр шалтгаангүйгээр хичээлээ тасалсан
- Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ сэтгэлийг зовоосон асуудлыг огт ойлгож, дэмждэггүй
- Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгааг эцэг эх, асран хамгаалагч нар анхаардаггүй байдал

3.2. ХООЛ ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭ

Хоногт хоол хүнсээр авах илчлэг болон хөдөлгөөний илч зарцуулалт хоорондын тэнцвэрт бус байдлаас үүдэн биеийн жин нэмэгдэж, илүүдэл жин ба таргалалт үүсдэг. Дэлхийн хүн амын дунд илчлэг өндөртэй боловч шимт чанар багатай, тос, чихэр, давс ихтэй эрүүл бус хүнсний хэрэглээ нэмэгдэж байгаа нь бүх насны хүмүүсийн дунд илүүдэл жин, таргалалт үүсэх үндсэн шалтгаан болж байна. Хоол тэжээлийн илүүдлээс үүсэх таргалалт нь өсвөр насны хүүхдийн оюун ухаан, бие махбодын хөгжилд сөрөг үр дагавартай, цаашлаад зүрх судасны өвчин, чихрийн шижин, элэг, цөсний эмгэг болон зарим төлийн хорт хавдраар өвдөх эрсдэлд хүргэдэг болохыг тогтоогоод байна [9]. Сургуулийн хүүхдүүдийн хувьд эрүүл бус (junk food) хоол, хүнсэнд багтдаг хийжүүлсэн болон чихэрлэг ундаа, бялуу, жигнэмэг, нарийн боов, чипс, шаржигнуур гэх мэт шарж бэлдсэн хоол хүнс ихээр хэрэглэж байгаа нь тэдний илүүдэл жин, таргалалттай болох нэг гол шалтгаан болж байна.

Хоол тэжээлийн дутлаас үүсэх уураг, илчлэг, А, Д аминдэм, төмрийн дутал нь таргалалтын нэг адил хүүхдийн эрүүл мэнд, суралцах чадварт сөргөөр нөлөөлдөг [3]. Иймээс аминдэм, эрдэс бодисын эх үүсвэр болсон хүнсний ногоо, жимс, жимсгэнээр баялаг хоол хүнсийг тогтмол хэрэглэх нь халдварт бус өвчний эрсдэлээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой [7].

Судалгаагаар суралцагчдын сүүлийн нэг долоо хоногт хэрэглэсэн жимс, хүнсний ногоо, түргэн хоол, хийжүүлсэн болон чихэрлэг ундаа зэрэг хоол, хүнсний талаар асуумж авч, хооллолтын байдлыг нь тодруулсан ба өглөөний цайгаа уудаг эсэх, гэрт нь хангалттай хоол хүнс байгаагүйгээс өлсдөг зэрэг асуултуудыг багтаасан.

3.2.1. Тураал, илүүдэл жин, таргалалт

Суралцагчдын жин, өндрийг хэмжиж, бие бялдрын өсөлт, хөгжилт, биеийн жингийн индексийг нь үнэлж, ДЭМБ-аас гаргасан өсөлтийн муруй ашиглан тураал, илүүдэл жин, таргалалтыг тогтоосон. БЖИ-ийн үнэлгээгээр нийт суралцагчдын 3.2% нь тураалтай, 14.6% нь илүүдэл жинтэй, 3.0% нь таргалалттай байна.

Эрэгтэй суралцагчдын 4.2%, эмэгтэй суралцагчдын 2.3% нь тураалтай байна. Хүйс, насны бүлэг, байршил тус бүрээр тураалтай, илүүдэл, жинтэй, таргалалттай суралцагчдыг үнэлэхэд харилцан адилгүй дүн үзүүлсэн ч статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа илрээгүй. (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Тураал, илүүдэл жин, таргалалттай суралцагчдын хувь, хүйс, байршлаар


Үзүүлэлтүүд	Тураал		Илүүдэл жин		Таргалалт	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
Хүйсээр						
Эрэгтэй	4.2	3.0-5.9	13.3	10.2-17.1	3.6	2.3-5.5
Эмэгтэй	2.3	1.5-3.6	15.7	13.3-18.5	2.5	1.7-3.6
Байршлаар						
Хот	3.1	2.3-4.0	14.5	11.3-18.5	3.0	2.0-4.5
Хөдөө	3.8	1.5-9.6	15.0	12.5-18.0	3.1	1.9-5.0
Нийт	3.2	2.4-4.4	4.2	3.0-5.9	2.3	1.5-3.6

3.2.2. Хоол хүнсний хэрэглээ

Суралцагчдын хооллолтын хэв маягийг тогтоохдоо сүүлийн долоо хоногт идсэн жимс, хүнсний ногоо, хийжүүлсэн болон чихэрлэг ундаа зэрэг хоол хүнсний хэрэглээгээр нь тодорхойлсон.

Нийт суралцагчдын 3.1% (95%CI 2.1-4.5) сүүлийн нэг сард гэрт нь хангалттай хоол, хүнс байгаагүйгээс өлссөн байна. Энэ үзүүлэлтийг байршлаар нь харьцуулахад хот, хөдөөд статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа илрээгүй (Зураг 1).

Зураг 1. Гэрт нь хоол хүнс хангалтгүйгээс өлссөн суралцагчдын хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)



Сүүлийн 7 хоногт нийт суралцагчдын 32.0% нь огт жимс идээгүй бол 89.0% нь нэгээс илүүгүй удаа жимс идсэн байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Жимсний хэрэглээ, хүйсээр (сүүлийн 7 хоногоор)

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
Огт идээгүй	32.0	29.9-34.1	30.2	28.0-32.4	33.6	30.7-36.7
Өдөрт нэгээс илүүгүй удаа	89.0	87.2-90.6	89.7	87.3-91.7	88.5	85.9-90.7
Өдөрт 2 ба түүнээс олон удаа	6.4	5.4-7.6	5.3	4.1-6.9	7.3	6.2-8.7
Өдөрт 3 ба түүнээс олон удаа	3.0	2.3-3.9	2.4	1.6-3.6	3.5	2.8-4.5

Сүүлийн долоо хоногт өдөрт 2 ба түүнээс олон удаа (6.4%, 95%CI 5.4-7.6), өдөрт 3 ба түүнээс олон удаа идсэн (3.0%, 95%CI 2.3-3.9) суралцагчид хотод илүү байв. Харин хүйсийн хувьд эмэгтэй суралцагчид эрэгтэйгээс илүү хэрэглээтэй ба анги ахих тутам жимсний хэрэглээ буурч байгаа нь ажиглагдав (Хавсралт 1).

Сүүлийн долоо хоногт хүнсний ногоог огт хэрэглээгүй суралцагчид 2.9% (95%CI 2.1-3.9) байсан (Хүснэгт 5) бөгөөд энэ үзүүлэлт нь хөдөө орон нутгийн суралцагчдын (5.7%, 95%CI 4.8-6.7) хувьд анги ахих тутам ихсэж байв (Хавсралт 1). Судалгааны үр дүнгээс харахад хүнсний ногоо хэрэглэх давтамж хотын суралцагчдын дунд илүү байна.

Хүснэгт 5. Хүнсний ногооны хэрэглээ, хүйсээр (сүүлийн 7 хоногоор)

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
Огт хэрэглээгүй	2.9	2.1-3.9	2.2	1.6-3.2	3.4	2.4-4.9
Өдөрт нэгээс илүүгүй удаа	40.2	36.4-44.0	39.0	34.2-44.0	41.1	37.2-45.1
Өдөрт 2 ба түүнээс олон удаа	36.3	32.8-40.0	39.2	35.5-43.0	33.7	29.0-38.7
Өдөрт 3 ба түүнээс олон удаа	13.8	12.4-15.3	16.8	14.8-19.0	11.0	8.9-13.3

Нийт суралцагчдын 29.1% (95%CI 25.7-32.8) нь сүүлийн долоо хоногт хийжүүлсэн ундааг огт угаагүй ба 87.3% (95%CI 85.1-9.3) өдөрт нэгээс илүүгүй удаа уусан байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Хийжүүлсэн ундааны хэрэглээ, хүйсээр (сүүлийн 7 хоногоор)

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
Огт уугаагүй	29.1	25.7-2.8	24.5	20.7-28.8	33.4	29.4-37.5
Өдөрт нэгээс илүүгүй удаа	87.3	85.1-9.3	87.9	85.7-89.8	87.0	83.5-89.8
Өдөрт 1 болон түүнээс олон удаа	12.7	10.8-14.9	12.1	10.2- 14.3	13.0	10.2-16.5
Өдөрт 2 болон түүнээс олон удаа	5.0	3.7-6.6	4.5	3.5-5.6	5.3	3.4-8.1
Өдөрт 3 ба түүнээс олон удаа	2.1	1.6-2.8	1.8	1.2-2.8	2.2	1.6-3.1

Байршил болон хүйсээр авч нь үзвэл нэг ба түүнээс олон удаа хийжүүлсэн ундаа уусан суралцагчдын хувьд ялгаатай байдал ажиглагдаагүй (Хавсралт 1). Харин хийжүүлсэн ундааг сүүлийн долоо хоногт 3 ба түүнээс олон удаа уусан суралцагчдын эзлэх хувь анги ахих тутам буурч байв.

Сүүлийн долоо хоногт суралцагчдын 31.1% (95%CI 27.9-34.6) нь чихэрлэг ундааг огт хэрэглээгүй бөгөөд хөдөө орон нутгийн суралцагчид (39.5%, 95%CI 34.7-44.4) хотынхоос 11.1%-иар илүү байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Чихэрлэг ундааны хэрэглээ, хүйсээр (сүүлийн 7 хоногоор)

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
Огт уугаагүй	31.1	27.9-34.6	29.6	25.1-34.6	32.6	28.8-36.7
Өдөрт нэгээс илүүгүй удаа	89.9	87.8-91.6	91.5	89.1-93.5	88.6	85.5-91.1
Өдөрт 1 болон түүнээс олон удаа	10.1	8.4-12.2	8.5	6.5-10.9	11.4	8.9-14.5
Өдөрт 2 болон түүнээс олон удаа	4.0	3.2-4.9	2.8	2.0-4.0	4.9	3.6-6.5
Өдөрт 3 ба түүнээс олон удаа	1.8	1.3-2.4	1.6	0.9-2.8	1.7	1.1-2.7

Чихэрлэг ундааг сүүлийн долоо хоногт нэг болон түүнээс олон удаа хэрэглэсэн эмэгтэй суралцагчдын хувь эрэгтэй суралцагчдаас илүү байна. Анги ахих тутам хөдөө орон нутгийн суралцагчдын хэрэглээ буурч байсан бол хотын суралцагчдын хувьд буурсан үзүүлэлт



ажиглагдсангүй. Мөн чихэрлэг ундааг өдөрт 3 ба түүнээс олон удаа хэрэглэж байгаа нь хүйс болон байршлын хувьд ялгаагүй байв (Хавсралт 1).

3.2.3. Хэлцэмж

Дэлхий нийтэд өсвөр үеийнхний дунд илүүдэл жин, таргалалт ихсэж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн анхаарал хандуулах нэг томоохон асуудал болоод байна. ДЭМБ-ын мэдээлснээр дэлхий дээр 340 сая гаруй 5-19 насны хүүхдүүд илүүдэл жин, таргалалттай буюу тархалтын хувь 18.0 байна [21]. Хүйсийн хувьд авч үзвэл илүүдэл жинтэй эмэгтэй хүүхэд 18.0%, эрэгтэй хүүхэд 19.0%, таргалалттай эмэгтэй хүүхэд 6.0%, эрэгтэй хүүхэд 8.0%-тай байна [2].

Манай улсын өсвөр насны хүүхдийн илүүдэл жин, таргалалт мөн адил сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. 2013 онд хийсэн судалгааны дүнгээр нийт суралцагчдын 10.6% нь илүүдэл жинтэй, 1.5% нь таргалалттай байсан бол 2023 оны энэ удаагийн судалгаагаар илүүдэл жин таргалалт хүйсийн хувьд ялгаагүй өссөн байна [8]. Цаашид өсвөр насны хүүхдийн илүүдэл жин, таргалалтыг бууруулах арга хэмжээг өргөн цар хүрээтэйгээр зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

Манай орны 13-15 насны суралцагчдын дундах илүүдэл жингийн тархалтыг (14.6%) ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн орнууд болох Лаос (11.6%), Индонез (15.3%), Вануату (14.9%) улсад хийсэн судалгааны дүнтэй харьцуулахад ойролцоо хувьтай байна [2]. Жимс, хүнсний ногооны хэрэглээ хангалтгүй байх нь ХБӨ-өөр өвчлөх анхдагч эрсдэлт хүчин зүйл гэж тооцдог [20]. Өсвөр үеийнхний жимс, ногооны хэрэглээ нь зохистой хооллолтын зөвлөмж хэмжээнд хүрэхгүй, хөдөө орон нутагт бага үзүүлэлттэй байгаа нь жимс, хүнсний ногооны нэр төрөл цөөн, олдоц муу, өртөг өндөр зэргээс шалтгаалсан байх магадлалтай.

Сүүлийн нэг сард гэрт нь хангалттай хоол, хүнс байхгүйгээс өлссөн суралцагчдын хувь 2013 онд 2.4% байсан бол энэ удаагийн судалгаагаар 3.1% болж нэмэгдсэн байна.

Суралцагчдын хийжүүлсэн ундааны хэрэглээ нь байршил болон хүйсийн хувьд ялгаа ажиглагдаагүй (Хавсралт 1), харин анги ахих тутам хэрэглээ нь буурсан эерэг үзүүлэлттэй байна.

3.2.4. Бүлгийн дүгнэлт:

1. Суралцагчдын 14.6% нь илүүдэл жинтэй, 3.0% нь таргалалттай байна. Илүүдэл жин, таргалалт нь 2013 оны судалгааны дүнтэй харьцуулахад хүйсийн хувьд ялгаагүй өссөн байна.
2. Байршлын хувьд харьцуулахад хотын суралцагчдын жимс, хүнсний ногооны хэрэглээ хөдөө орон нутгийн суралцагчдаас их байв.
3. Сүүлийн 7 хоногт хийжүүлсэн ундаа огт уугаагүй суралцагчид хотод 27.0%, хөдөөд 35.8%, чихэрлэг ундаа огт уугаагүй суралцагчид хотод 28.4%, хөдөөд 39.5% байна.

3.3. ЭРҮҮЛ АХУЙН ДАДАЛ

Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой үйлчилгээ нь хүүхдийг эрүүл аюулгүй орчинд, сурч боловсрох эрхийг хангаж буйг илэрхийлэх гол үзүүлэлт юм. Сургуулийн орчинд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн хүртээмжгүй байдал нь суралцагчдын ирц, сурлагын амжилтыг бууруулах нөлөөтэй байдаг [22] ба харин сургуулийн орчинд аюулгүй ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн зохистой дадалд суралцсан хүүхдүүд гэр орон, нийгэмдээ насан туршийн эерэг зан үйлтэй болдог байна. Дэлхий дээр 802 сая гаруй хүүхдэд сургуулийн орчинд гарын эрүүл ахуй сахиx нөхцөл бүрдээгүй бөгөөд бага сургуулийн 42.0%, дунд сургуулийн 40.0% нь гарын эрүүл ахуй сахиx үндсэн үйлчилгээгээр хангагдаагүй байдгийг судалгаагаар тогтоожээ [23].

Амны хөндийн эрүүл мэнд муу байх нь биеийн ерөнхий эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлдөг. Мөн суралцагчдын сурах чадвар, танин мэдэхүйд сөргөөр нөлөөлж, өөртөө итгэх итгэл болон үнэлэх үнэлэмж буурдаг. Өсвөр насандаа шүдээ тогтмол угааж хэвших нь насанд хүрсэн хойноо ч хадгалагддаг бөгөөд зүрх судасны өвчлөл болон бодисын солилцооны хам шинжийн


эрсдэлт хүчин зүйлсээс хамгаалдаг. Дэлхий дээр бага болон дунд орлоготой орнуудын өсвөр насныхны 5.0-10.0% нь шүдээ ховор эсвэл огт угаадаггүй байна [24].

2015-2016 онд БНХАУ-д хийсэн судалгаагаар 12-15 насны суралцагчдын 32.6% нь өдөрт 2 удаа шүдээ угаадаг, 7.4% нь фтортой оо хэрэглэдэг, шүдээ угаах эерэг дадал нь 15 насны охидуудад илүү байгааг тогтоожээ [25].

3.3.1. Суралцагчдын шүдээ угаах дадал

Суралцагчдын 6.5% (95% CI 5.1-8.1) нь сүүлийн нэг сард шүдээ огт угаагаагүй болон өдөрт нэгээс цөөн удаа угаагасан байв (Зураг 2). Энэ сөрөг дадал нь анги ахих тутам буурах хандлагатай байна.

Зураг 2. Шүдээ угаагаагүй болон өдөрт нэгээс бага угаадаг суралцагчдын хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)




Нийт суралцагчдын 34.0% (95% CI 30.0-38.3) шүдээ угаахдаа фтортой оо хэрэглэдэг бол хот хөдөөд ялгаатай байдал ажиглагдсангүй.

Сүүлийн нэг сард амны хөндийн эрүүл мэндийн шалтгаанаар хичээлээ тасалсан суралцагчид 8.0% (95% CI 6.3-10.0), хотод 7.7% (95% CI 5.6-10.5), хөдөөд 8.9% (95% CI 7.0-11.1) байна. Энэ үзүүлэлт нь хүйсийн хувьд төдийлөн ялгаагүй ба 16-17 насны суралцагчдын дунд 13-15 насны бүлэгтэй харьцуулахад их байна.

3.3.2. Суралцагчдын гараа угаах дадал

Нийт суралцагчдын 4.2% (95% CI 3.1-5.7) нь сүүлийн нэг сард ариун цэврийн өрөө, жорлон орсны дараа гараа огт угаагаагүй болон ховор угаасан байна (Зураг 3). Энэ сөрөг дадал нь анги ахих тутам буурах хандлагатай бөгөөд хөдөөд хотоос илүү байна.

Зураг 3. Гар угаах зохисгүй дадалтай суралцагчдын эзлэх хувь, байршлаар ба хүйсээр, (сүүлийн нэг сараар)





Энэ үзүүлэлт нь 13-15 насны суралцагчид (4.7%, 95%CI 3.5-6.3)-ыг 16-17 насны бүлэгтэй (3.3%, 95%CI 1.8-6.1) харьцуулахад их байсан бол хүйсийн хувьд статистик ялгаа ажиглагдаагүй.

Харин суралцагчдын 4.0% (95%CI 2.8-5.8) нь сүүлийн нэг сард гараа угаахдаа саван огт хэрэглээгүй болон ховор хэрэглэсэн байна. Ариун цэврийн өрөө орсны дараа гараа угаахдаа саван хэрэглэдэггүй байдал нь эрэгтэй сурагцагч (4.4%, 95%CI 2.9-6.7) болон хөдөөд илүү (5.9%, 95%CI 3.8-9.1) байгаа нь үр дүнгээс ажиглагдлаа.

3.3.3. Хэлцэмж

Боловсролын орчинд ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, хүрэлцээ муу байх нь суралцагчдад эрүүл ахуйн зохистой дадал хэвшдэггүй, хичээл таслалт нэмэгддэг байна [22]. Мөн нян, шимэгч хорхойн халдвараар өвчлөх эрсдэлийг бий болгодог.

2013 оны судалгааны дүнгээр суралцагчдын 5.3% нь сүүлийн нэг сард шүдээ огт угаагүй болон нэгээс цөөн удаа угаадаг байсан [8] бол 2023 оны судалгаагаар энэ үзүүлэлт 6.5% болж нэмэгдсэн байна. Ихэвчлэн эрэгтэй суралцагчид шүдээ угаадаггүй буруу дадалтай байна.

Өмнөх судалгаагаар сүүлийн нэг сард хоол идэхийн өмнө гараа огт угаагаагүй болон ховор угаасан суралцагчид 7.7% байсан [8] бол 2023 оны судалгаагаар 5.7% (95%CI 4.7-6.9) болж буурсан сайн үзүүлэлттэй байна.

Хоол идэхийн өмнө болон ариун цэврийн өрөө, жорлон орсны дараа гараа угаах дадал энэ удаагийн судалгаагаар нэмэгдсэн хэдий ч гараа угаахдаа саван хэрэглэх байдалд төдийлөн ялгаа ажиглагдсангүй.

Лаос улсад 2015 онд хийгдсэн судалгаагаар суралцагчдын 97.7% нь сүүлийн нэг сард өдөрт нэг ба түүнээс олон удаа шүдээ угаасан эерэг дадалтай байсан бол 2023 оны судалгаагаар энэ үзүүлэлт 93.5% болж буурсан байна [26].

Сүүлийн нэг сард ариун цэврийн өрөө, жорлон орсны дараа гараа огт угаагаагүй болон ховор угаасан үзүүлэлт ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн орнууд болох Лаос-3.4%, Индонез-2.3%, Самоа-6.3%, Ниуэ-3.4% байгаа нь манай улстай ойролцоо (4.2%, 95%CI 3.1-5.7) үзүүлэлттэй байна [26,27,28,32].

Манай улсад 2015 оноос хойш цэцэрлэг, ЕБС, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн норм, шаардлагыг боловсруулан, хэрэгжүүлж байгаа хэдий ч суралцагчдын амны хөндийн эрүүл ахуй болон гар угаах зөв дадалд ахиц гарахгүй байна. Цаашид ЕБС-ийн орчинд гар угаах орчин, нөхцлийг бүрдүүлж, эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага, зөв дадлыг дээшлүүлэх чиглэлээр анхаарч ажиллах зайлшгүй шаардлагатай байна.

3.3.4. Бүлгийн дүгнэлт:

1. Суралцагчдын 93.5% (95%CI 91.9-94.9) нь өдөрт нэг ба түүнээс олон удаа шүдээ угаадаг зөв дадалтай байна. Энэ үзүүлэлт 16-17 насны бүлэгт, ялангуяа эмэгтэй суралцагчдад илүү байна.
2. Ариун цэврийн өрөө, жорлон орсны дараа гараа огт угаагаагүй болон ховор угаасан байдал 4.2% (95%CI 3.1-5.7) байсан бол гараа угаахдаа саван огт хэрэглээгүй гэх сөрөг дадалтай суралцагчид 4.0% (95%CI 2.8-5.8) байв. Энэ дадал хөдөөгийн суралцагчдад илүү байв.

3.4. ОСОЛ ГЭМТЭЛ, ХҮЧИРХИЙЛЭЛ

ДЭМБ-ын 2021 оны мэдээллээр жил бүр осол гэмтлийн улмаас 4.4 сая хүн амь насаа алдаж байгаа бөгөөд энэ нь нийт нас баралтын 8 орчим хувийг эзэлж байна [29].


Манай улсад 0-18 насны хүүхдийн осол гэмтэл нь нийт осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн 35 орчим хувийг эзэлдэг. Хүүхдийн осол гэмтлийн өвчлөлийн 62.1% эрэгтэй, 37.9% эмэгтэй байна [30]. Осол гэмтэлд өртөх тохиолдлыг хүйсээр харьцуулан үзэхэд эрэгтэй хүүхдүүдэд эмэгтэй хүүхдүүдээс 1.8 дахин их байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол улсын хэмжээнд 0-18 насны хүүхдийн 244,987 осол гэмтлийн тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүний 47.6% уналт, 15.3%

амьгүй механик хүчинд өртөх, 10.1% зам тээврийн осол, 9.7% амьтай механик хүчинд өртөх, 8.0% түлэгдэлт тус тус эзэлж байна [30].

3.4.1. Осол гэмтэл

Нийт суралцагчдын 39.6% (95%CI 36.4-42.8) нь сүүлийн нэг жилд осол гэмтэлд өртсөн бөгөөд эрэгтэй суралцагчдын (41.7%, 95%CI 37.6-45.9) дунд илүү байна (Зураг 4). Насны бүлгээр нь харьцуулахад статистик ялгаа ажиглагдсангүй (Хавсралт 1).


Зураг 4. Осол гэмтэлд өртсөн хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг жилээр)



Осол гэмтэлд өртсөн байдлыг байршлаар нь авч үзэхэд хотод (41.3%, 95%CI 37.1-45.6), хөдөөгөөс (33.9%, 95%CI 29.5-38.7) илүү байсан ч статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна.

Нийт суралцагчдын 24.9% (95%CI 20.6-29.7) яс хугарсан, үе мултарсан, шүд хугарсан зэрэг аюултай осол гэмтэлд өртсөн бөгөөд энэ үзүүлэлт эрэгтэй суралцагчдын (31.5%, 95%CI 25.7-38.0) хувьд илүү байна (Зураг 5).


Зураг 5. Сурагчдад тохиолдсон аюултай осол гэмтлийн хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг жилээр)



Байршлын хувьд хот, хөдөөд ялгаагүй эрэгтэй суралцагчдын сүүлийн нэг жилд осолд гэмтэлд өртсөн хувь эмэгтэйдээс илүү байв.

Зам тээврийн осол болох тээврийн хэрэгсэлд мөргүүлснээс шалтгаалж осол, гэмтэлд өртсөн суралцагчид 5.4% (95%CI 3.9-7.4) байгаа нь 2013 оны судалгааны дүнгээс буурсан байна (Зураг 6).

Зураг 6. Зам тээврийн осолд өртсөн суралцагчдын хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг жилээр)




Зам тээврийн осолд өртсөн байдалд нь хотод эрэгтэй суралцагчид илүү их өртөж байсан бол хөдөөд эмэгтэй суралцагчид байв. Насны бүлгээр авч үзвэл 16-17 насны эмэгтэй суралцагчид илүү их өртсөн байлаа (Хавсралт 1).

3.4.2. Хүчирхийлэл

Нийт суралцагчдын 23.3% (95%CI 21.2-25.6) нь сүүлийн нэг жилийн хугацаанд бусдад зодуулсан ба эрэгтэй суралцагчдын хувь их байв. Байршлын хувьд хот хөдөөгийн суралцагчдын хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй.


Зураг 7. Бусадтай зодолдсон суралцагчдын хувь, байршил ба хүйсээр, (сүүлийн нэг жилээр)



Харин бусадтай зодолдсон байдал нь нийт суралцагчдын 28.3% (95%CI 26.1-30.6)-ийг эзэлж байгаа бөгөөд эрэгтэй суралцагчдын (37.8%, 95%CI 35.0-40.7) хувь эмэгтэй суралцагчдаас (19.2% 95%CI 16.8-21.9) илүү байна. Энэ үзүүлэлт анги ахих тутам буурах хандлагатай байв. Байршлын хувьд хот (37.2%, 95%CI 33.1-41.5) хөдөөд (38.8%, 95%CI 34.8-42.8) ялгаагүй эрэгтэй суралцагчид илүү бусадтай зодолдсон байгаа ч статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй (Зураг 7).

Сүүлийн нэг сарын байдлаар сургуулийн орчинд нийт суралцагчдын 26.9% (95%CI 25.2-28.6), сургуулийн бус орчинд 17.4% (95%CI 15.5-19.5) дээрэлхүүлсэн байна (Зураг 8).


Зураг 8. Сургуулийн орчинд дээрэлхэлтэд өртсөн хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)



Дээрэлхэлтэд өртсөн байдал нь хот, хөдөөд ялгаагүй 13-15 насны эрэгтэй суралцагчид илүү өртдөг байлаа (Хавсралт 1).

Сүүлийн нэг жилийн хугацаанд цахим дээрэлхэлтэд нийт суралцагчдын 17.9% (95%CI 16.5-19.3), үүнээс эрэгтэй 14.1% (95%CI 12.3-16.0), эмэгтэй 21.3% (95%CI 19.2-23.6) байна (Зураг 9).


Зураг 9. Цахим хүчирхийлэлд өртсөн суралцагчдын хувь, хүйсээр (сүүлийн нэг жилээр)



Цахим дээрэлхэлтэд өртсөн байдал хотод 18.5% (95%CI 16.7-20.4), хөдөөд 15.6% (95%CI 13.3-18.3) байгаа бөгөөд байршлын хувьд ялгаагүй эмэгтэй суралцагчид илүү өртөх хандлагатай байна (Хавсралт 1).



Зураг 10. Хүчирхийлэлд өртсөн суралцагчдын хувь, төрлөөр (сүүлийн нэг жилээр)



Цахим дээрэлхэлтийг төрлөөр нь авч үзвэл ёс бус утгатай, зураг, бичлэг хүлээн авсан 39.2% (95%CI 34.4-44.3), нийгмийн сүлжээнд бэлгийн харьцаатай холбоотой зүйл хийхийг нэг ба түүнээс олон удаа албадсан 5.9% (95%CI 4.8-7.3) тус тус байгааг энэ удаагийн судалгаагаар тогтоолоо (Зураг 10).

Сүүлийн нэг жилийн хугацаанд багшдаа (алгадах, өшиглөх, юм мөргүүлэх, цохих, удаан хугацаагаар зогсоох, мөлхүүлэх зэргээр) шийтгүүлж байсан суралцагчид 26.7% (95%CI 23.5-30.1) байсан бол багш нь айлгах, ичээх, доромжлох, нэр хоч өгөх, загнах зэргээр дарамтласан байдал 32.9% (95%CI 29.6-36.4)-ийг эзэлж байна (Зураг 10).

Байршлын хувьд ялгаагүй хот, хөдөөгийн 16-17 насны эрэгтэй суралцагчид илүү өртсөн байна (Хавсралт 1).

3.4.3. Хэлцэмж

Нийт суралцагчдын 39.6% сүүлийн нэг жилийн хугацаанд осол гэмтэлд өртсөн байна. Энэ үзүүлэлт 2013 онд хийгдсэн судалгааны дүнтэй (36.3%) [8] харьцуулахад 3.3 пунктээр нэмэгдсэн байна.

Олон улсын судалгаатай харьцуулбал, сүүлийн нэг жилд манай улсын суралцагчдын осол гэмтэлд өртсөн байдал Күүкийн арал болон Индонез улсын үзүүлэлтээс 2 дахин бага байна [27].

Энэ удаагийн судалгаагаар бусадтай зодолдсон суралцагчид 23.3% байна. Үүнээс эрэгтэй суралцагчид 25.3% байгаа нь эмэгтэй суралцагчдаас илүү байв.

Индонези улсад хийсэн судалгаагаар сүүлийн нэг жилд бусадтай зодолдсон суралцагч 24.6%, үүний 35.9% эрэгтэй суралцагч байна [27]. Энэ үзүүлэлт Вануату 59.1%, Фижи арал 46.7%, Филиппин 43.7%, Нируэ 48.2%-тай байна [31,32,40,41]. Бүс нутгийн судалгааны дүнтэй харьцуулахад сүүлийн нэг жилийн хугацаанд нэг болон түүнээс олон удаа зодолдсон суралцагчийн хувь ойролцоо байна.

Нийт суралцагчдын 26.7% (95%CI 25.2-28.6) нь хүчирхийлэлд өртсөн ба 2013 оны судалгаатай 1.4 хувиар буурсан байна. Цахим хүчирхийлэлд өртсөн байдал 18.5% байна. Энэ үзүүлэлт дэлхийн бусад оронд харилцан адилгүй хувьтай байлаа (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Номхон далайн баруун бүсийн зарим орнуудын суралцагчдын зодолдсон, осол гэмтэлд өртсөн, бусдад дээрэлхүүлсэн байдал, сүүлийн нэг жилээр [33]

Номхон далайн эргийн зарим улс орнууд	Нэг ба түүнээс олон удаа зодолдсон байдал, %	Осол гэмтэлд өртсөн байдал, %	Нэг ба түүнээс олон өдөр дээрэлхүүлсэн байдал, %
Бүгд Найрамдах Вануату улс, 2016	40.2	59.1	50.4
Филиппин, 2019	31.0	43.7	40.7
Ниуэ, 2019	35.4	48.2	36.3
Лаос, 2015	7.6	16.8	11.8
Индонез, 2015	22.6	29.4	20.6
Фижи арал улс, 2016	32.8	46.7	27
Күүкийн арлууд, 2015	27.4	52.1	26.8
Монгол улс, 2023	28.5	39.8	26.0

Бэлгийн харьцаатай холбоотой үйлдлийг албадан хийлгэсэн гэж суралцагчдын 9.3% хариулсан байна. Мөн эмэгтэй суралцагчдын хувьд цахим орчны зохисгүй харьцаа их хувьтай байгаа нь цаашид анхаарах асуудал болж байна.

Багшдаа шийтгүүлсэн суралцагчид 26.7%, дарамтлуулсан суралцагчид 32.9% байгаа нь багш, сурагч хоорондын харилцаа, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг тогтмол зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

3.4.4. Бүлгийн дүгнэлт:

1. Сүүлийн нэг жилийн хугацаанд нийт суралцагчдын 23.3% бусдад зодуулсан байна. Бусдад зодуулсан эрэгтэй суралцагчид 25.3% (95%CI 22.4-28.4), эмэгтэй суралцагчид 21.5% (95%CI 18.9-24.5)-тай байна. Суралцагчдын нас бага байхад бусдад зодуулсан хувь их байна.
2. 10 суралцагч тутмын 4 нь осол гэмтэлд өртсөн бөгөөд эрэгтэй суралцагчид илүү өртөж байна. Суралцагчид унаж бэртсэний улмаас яс хугарах, толгой хүзүүний гэмтэл авах зэрэг гэмтэлд илүү өртөж байна.
3. Суралцагчдын цахим хүчирхийлэлд өртсөн байдал 17.7% (95%CI 16.4-19.0) байгаа бөгөөд эмэгтэй суралцагчид илүү өртөж байна.
4. Багш нарын шийтгэл, дарамтыг 10 суралцагч тутмын 3 нь мэдэрдэг байна.

3.5. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

Хүүхэд, өсвөр үе бол хүний амьдралын бие хүн болон төлөвших чухал үе шат юм. Бие махбод, сэтгэл санаа, нийгмийн сөрөг өөрчлөлт (ядуурал, дайн, хүчирхийлэл зэрэг) нь өсвөр насны хүүхдүүдийг сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд өртөмтгий болгодог байна. Өсвөр насныхныг зовлон бэрхшээлээс хамгаалах, нийгэм-сэтгэл санааны боловсрол, сэтгэл зүйн сайн, сайхан байдлыг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд, хүртээмжтэй олгох нь насанд хүрсэн хүний эрүүл мэнд, сайн сайхан байдалд нэн чухал юм. Учир нь бага насанд тохиолдсон сэтгэлзүйн гэмтэл тухайн хүүхдийг эрүүл аж төрөх, нийгэмших үйл явцад саад учруулдаг.

Дэлхий дахинд хүүхэд өсвөр үеийнхний 14.0% нь сэтгэцийн болон төрх үйлийн асуудалтай тулгардаг гэсэн тоо баримт байна. АНУ-д хийгдсэн судалгаагаар 4-17 настай хүүхдүүдийн 56.0% нь сэтгэцийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай гэж тогтоогдсон.

Монгол улсад өсвөр үеийнхний 25.7% нь ганцаардал болон сэтгэл гутралд ордог гэсэн судалгааны дүн байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай өсвөр насныхан нийгмээс гадуурхагдах, бусдыг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох, сурч боловсрох байдал алдагдах,

эрсдэлд орох, бие махбод, эрүүл мэндийн хэвийн байдал алдагдах, хүний эрхийн зөрчилд өртөмтгий болдог байна [34].

3.5.1. Сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудал

Энэ бүлэгт суралцагчдын ганцаардал, нойргүйдэл, стресс, бухимдлаа хэрхэн удирдах талаар хичээл орсон байдал болон амиа хорлох бодол төрж байсан эсэх, төлөвлөж байсан эсэх, оролдлого хийж байсан эсэх зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн асуудлуудыг судалсан.

Суралцагчдын 24.3% (95%CI 22.2-26.4) байнга ганцаарддаг байна. Байнга ганцаарддаг эмэгтэй суралцагчдын хувь эрэгтэй суралцагчдаас ойролцоогоор 2 дахин их байна. Байршлаар нь авч үзэхэд хөдөө 18.1% (95%CI 15.6-21.0), хот 26.1% (95%CI 23.5-28.9) байна.

Ямар нэг зүйлд санаа зовсноос болж шөнө унтаж чадаагүй суралцагчид 12.5% (95%CI 10.8-14.5) бөгөөд энэ үзүүлэлт эмэгтэй суралцагчдад (16.4%, 95%CI 14.0-19.1) илүү байна.

Сүүлийн нэг жилийн хугацаанд амиа хорлох талаар бодож байсан 39.0% (95%CI 36.3-41.8), төлөвлөж байсан 22.2% (95%CI 20.0-24.6), нэг ба түүнээс олон удаа оролдлого хийсэн 15.8% (95%CI 13.8-18.0) байна.

Дотны сайн найзгүй гэж хариулсан суралцагчдыг хүйсийн хувьд харьцуулахад эмэгтэй суралцагчид (9.9%, 95%CI 7.7-12.5) эрэгтэй суралцагчдаас (6.6%, 95%CI 5.3-8.2) их байлаа.


Нийт суралцагчдын 46.4% хичээлийн жил эхэлснээс хойш стресс, уур бухимдаа хэрхэн удирдах талаар хичээл, сургалтад хамрагдаж байсан байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Суралцагчдын сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд, хүйсээр (сүүлийн нэг жилээр)

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
Дотны найзгүй	8.2	6.8 - 10.0	6.6	5.3 - 8.2	9.9	7.7 - 12.5
Байнга ганцаардаж байсан	24.3	22.2 - 26.4	16.8	14.3 - 19.6	31.5	28.6 - 34.5
Ямар нэг зүйлд санаа зовсноос болж шөнө унтаж чадаагүй	12.5	10.8 - 14.5	8.5	6.7 - 10.8	16.4	14.0 - 19.1
Стресс, уур бухимдлаа хэрхэн удирдах талаар хичээл, сургалтад хамрагдсан	46.1	42.1 - 50.1	42.5	38.6 - 46.5	49.6	44.5 - 54.7
Амиа хорлох талаар бодож байсан	39.0	36.3 - 41.8	28.3	24.6 - 32.3	49.1	45.1 - 53.2
Амиа хорлох талаар төлөвлөж байсан	22.2	20.0 - 24.6	16.1	13.9 - 18.6	27.9	24.8 - 31.3
Амиа хорлох гэж нэг ба түүнээс олон удаа оролдож байсан	15.7	13.8 - 17.9	10.2	8.1 - 12.8	20.6	17.8 - 23.5

Амиа хорлох талаар бодож байсан суралцагчдыг байршлаар нь харьцуулан авч үзэхэд хотод 41.7% (95%CI 38.0-45.4), хөдөөд 29.5% (95%CI 26.2-33.1) байна. Энэ үзүүлэлтийг насны бүлэг, хүйсээр нь харьцуулан авч үзэхэд 13-15 насны эмэгтэй суралцагчдад хамгийн их буюу 49.4% (95%CI 44.1-54.7)-тай байна (Зураг 11).

Зураг 11. Амиа хорлох талаар бодож байсан болон оролдлого хийсэн суралцагчдын хувь, байршлаар (сүүлийн нэг жилээр)



3.5.2. Хэлцэмж

Өсвөр үеийнхэнд насны онцлог, сэтгэл хөдлөл, зан үйл, сурахтай холбоотой сэтгэцийн эрүүл мэндийн асуудал байнга тохиолддог байна [34].

2013 онд хийгдсэн судалгааны дүнгээр суралцагчдын 11.9% нь ганцаарддаг байсан [8] бол энэ судалгааны дүнгээр 24.3% буюу ойролцоогоор 2 дахин их болж өссөн байна. Ямар нэг зүйлд санаа зовсноос болж шөнө унтаж чадаагүй суралцагчид 12.9% байгаа нь мөн 2 дахин өссөн байна.

Амиа хорлох талаар бодсон, төлөвлөсөн, оролдлого хийсэн суралцагчид 2010, 2013 оны судалгааны дүнтэй харьцуулахад ихэссэн байна. Тухайлбал 2010 оны судалгааны дүнгээр суралцагчдын 19.3% нь амиа хорлохоор бодож, 12.4% нь амиа хорлохоор төлөвлөж, 8.6% нь амиа хорлохоор оролдож байсан [7,8] бол эдгээр үзүүлэлтүүд энэхүү судалгаагаар 38.9%, 22.0%, 15.7% болж ойролцоогоор 2 дахин болж өссөн байна.

Мөн дотны найзгүй суралцагчид 7.9% байгаа бөгөөд 2010, 2013 онд хийгдсэн судалгааны дүнгээс өссөн байна.

Хичээлийн жил эхэлснээс хойш стресс, бухимдлаа хэрхэн удирдах талаар хичээл, сургалтад хамрагдаж байсан суралцагчид 2010 онд 38.0%, 2013 онд 35.3% байсан бол 2023 онд 46.4% болж өссөн сайн үзүүлэлттэй байна.

2015 онд Индонези улсад хийсэн судалгаагаар суралцагчдын 5.1% нь амиа хорлох оролдлого хийж байсан бөгөөд энэ үзүүлэлт ДЭМБ-ын НДББ-ийн орнууд болох Лаосд 5.9%, Самоод 22.3%, Ниуэд 10.8% байна [26,27,28,32]. Эдгээр судалгааны дүнтэй харьцуулахад манай улсад энэ үзүүлэлт 15.7% буюу Индонези, Лаос улсын суралцагчдын үзүүлэлтээс 3 дахин их, Самоа улсын суралцагчдын үзүүлэлтээс бага үзүүлэлттэй байна [26,27,28].

Манай улсад 2018 оноос эхлэн ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлийг багтаан, зааж эхэлсэн хэдий ч судалгааны үр дүнгээс харахад эрүүл мэндтэй холбоотой сөрөг үзүүлэлтүүд ихэссэн нь хичээлийн үр дүн муу байна гэх дүгнэлтэд хүрч байна. Тиймээс цаашид эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийг үнэлэх, шинэчлэн боловсруулах шаардлагатайгаас гадна өсвөр үеийнхний эрүүл мэнд ялангуяа сэтгэцийн эрүүл мэндийн асуудал руу чиглэсэн үр дүнтэй ажил хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.5.3. Бүлгийн дүгнэлт:

1. 4 суралцагч тутмын нэг нь байнга болон ихэвчлэн ганцаарддаг, тэр дундаа эмэгтэй суралцагчид илүү их ганцаардалд өртөж байна.
2. 3 суралцагч тутмын нэг нь амиа хорлох талаар бодож, 5 суралцагч тутмын нэг нь амиа хорлохоор төлөвлөж, 7 суралцагч тутмын нэг нь амиа хорлох оролдлого хийсэн байна. Амиа хорлох талаар бодож, төлөвлөж, оролдлого хийсэн үзүүлэлт нь эмэгтэй суралцагчдын дунд илүү байгаа нь статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна.
3. Суралцагчдын дийлэнх хэсэг нь сэтгэл зүйн ямар нэг асуудалтай тулгардаг хэдий ч тэдний тал нь буюу 2 суралцагчийн нэг нь стресс, уур бухимдлаа удирдах, хэрхэн зөв аргаар тайлах талаар хичээл, сургалтад хамрагдсан байна.

3.6. ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Дэлхий дээр ойролцоогоор 1.3 тэрбум хүн тамхи татдаг бөгөөд энэ тоо жил ирэх тутам нэмэгдсээр байна. Тамхи татагчдын 80 орчим хувь нь бага болон дунд орлоготой улс орнуудад амьдарч байна. Дэлхий дээр жилд 8 сая хүн тамхины улмаас хорвоог орхиж байна. Эдгээр хүмүүсийн 1.3 сая орчим тамхи татдаггүй хүн дам тамхидалтад өртсөний улмаас нас бардаг байна [35]. Тамхины тархалт нь нийгмийн эрүүл мэндэд ноцтой үр дагаварт хүргэх, дэлхий дахины томоохон асуудал болоод байна. Түүнчлэн хүүхэд, өсвөр үеийнхний дунд тамхи татах болон тамхийг бусад замаар хэрэглэх хандалага олон улсад нэмэгдэж байгаа нь анхаарал хандуулах шаардлагатай байгааг сануулсаар байна.


Өсвөр насандаа тамхи татах нь эрүүл мэндэд маш хортой төдийгүй олон архаг өвчний суурийг тавина. Хүүхэд, өсвөр үеийнхний тамхи татахад эцэг эхийн тамхи татах дадал сөргөөр нөлөөлдөг болохыг эрдэмтэд батлаад байна.

2023 онд АНУ-ын ӨХСТ-ийн судалгаагаар ахлах ангийн суралцагчдын 10.0%, дунд ангийн суралцагчдын 4.6 % сүүлийн нэг сард электрон тамхи татсан гэсэн үзүүлэлттэй байна [36].

3.6.1. Суралцагчдын тамхины хэрэглээ

Суралцагчдын 19.9% нь тамхи татаж үзсэн байна. Тамхи татаж үзсэн нийт суралцагчдын 38.4% (95%CI 35.2-41.6) нь тамхийг ганц, хоёр удаа сорж, туршиж үзсэн бол 56.5% нь (95%CI 51.1-61.7) нь 14 наснаасаа өмнө тамхи татсан байна. 14 түүнээс бага насандаа тамхи татаж үзсэн сурагчдыг хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэй (58.7%, 95%CI 51.8-65.2) сурагчид эмэгтэй (52.4%, 95%CI 44.9-59.7) сурагчдаас илүү байв (Зураг 12).

Зураг 12. Тамхийг ганц, хоёр удаа сорж, туршиж үзсэн болон 14 наснаасаа өмнө татсан суралцагчдын хувь, хүйсээр



■ Тамхийг ганц хоёр удаа сорж, туршиж үзсэн

■ 14 наснаасаа өмнө тамхи татсан

Хотын суралцагчдын 56.5% (95% CI 49.3-63.4), хөдөөгийн суралцагчдын 57.5% (95% CI 51.0-63.7) нь тамхийг 14 наснаасаа өмнө татаж үзсэн байна. Энэ үзүүлэлт нь эрэгтэй суралцагчдын дунд илүү байв (Хавсралт 1).

Суралцагчдын одоогийн тамхины хэрэглээг тогтооход нийт суралцагчдын 11.1% нь сүүлийн 30 хоногт хамгийн багадаа нэг өдөр тамхи татсан байна. Энэ үзүүлэлт нь 2013 онд суралцагчдын 9.4% байсан бол 2023 онд нэмэгдсэн байна.

Сүүлийн нэг сард тамхи татсан эрэгтэй суралцагчид (17.2%, 95%CI 14.0-20.8) эмэгтэй суралцагчдаас (5.3%, 95%CI 4.0-7.1) 3.2 дахин илүү байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Хамгийн багадаа нэг өдөр тамхи татсан суралцагчдын хувь, хүйс ба насны бүлгээр (сүүлийн нэг сараар)

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
13-15	8.6	7.0-10.5	13.4	11.0-16.2	3.8	2.5-5.7
16-17	15.8	11.1-22.0	24.7	17.2-34.0	8.1	4.8-13.3
Нийт	11.1	9.0-13.5	17.9	14.6-21.7	5.5	4.2-7.3

Нас ахих тутам суралцагчдын тамхи татаж байгаа хувь нэмэгдэж байна. Аль ч ангид эрэгтэй суралцагчдын тамхи татаж байгаа хувь эмэгтэйчүүдээс илүү байна. Тамхины хэрэглээ хөдөө орон нутгийн суралцагчдын (12.2%, 95%CI 9.6-15.4) дунд хотын суралцагчдын үзүүлэлтээс (10.9%, 95%CI 8.3-14.2) их байв (Хавсралт 1). Хотын эрэгтэй суралцагчдын 16.6% (95%CI 12.7-21.5), эмэгтэй суралцагчдын 5.5% (95%CI 3.8-8.0) нь тамхи татдаг байв. Харин хөдөөгийн эрэгтэй суралцагчдын 20.5% (95%CI 16.4-25.3), эмэгтэй суралцагчдын 4.2% (95%CI 3.0-5.9) нь тамхи татсан байна (Хавсралт 1).


Сүүлийн 30 хоногт янжуураас бусад навчин тамхи, гаанс зэрэг утаат тамхи татсан суралцагчдын эзлэх хувь хотын суралцагчдын хувь (эрэгтэй 13.7%, 95%CI 10.7-17.3, эмэгтэй 5.6%, 95%CI 4.0-7.9) хөдөө орон нутгийн сурагчдаас их байв (Хавсралт 1).

3.6.2. Дам тамхидалтад өртсөн байдал

Нийт суралцагчдын 63.2% (95%CI 59.4-66.8) нь сүүлийн 7 хоногт дам тамхидалтад өртсөн байна.

Дам тамхидалтад өртсөн суралцагчдын хувь хотод 64.4% (95%CI 59.4-69.1), хөдөөд 58.7% (95%CI 53.6-63.6) байв. Судалгааны дүнгээс харахад хотын суралцагчид илүү дам тамхидалтад өртөж байна (Зураг 13). Харин хүйсийн хувьд хот, хөдөөд ялгаагүй эрэгтэй суралцагчид дам тамхидалтад өртөх нь их байна (Хавсралт 1).

Зураг 13. Дам тамхидалтад өртсөн суралцагчдын хувь, байршил ба хүйсээр (сүүлийн долоо хоногоор)




3.6.3. Электрон тамхины хэрэглээ

Нийт суралцагчдын 24.8% (95%CI 20.9-29.2) нь сүүлийн 30 хоногт электрон тамхи татсан байв. Электрон тамхийг ахлах ангийн эрэгтэй суралцагчид бусдаасаа илүү их хэрэглэж байгааг энэхүү судалгаагаар тогтоов.

Үүнийг байршлаар авч үзвэл хотод 27.4% (95%CI 22.5-32.9), хөдөөд 16.5% (95%CI 11.6-22.9) суралцагчид электрон тамхийг хэрэглэж байна (Зураг 14).

Зураг 14. Электрон тамхины хэрэглээ, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)



16-17 насны суралцагчдын электрон тамхины хэрэглээ сүүлийн 30 хоногт 34.2% (95%CI 26.1-43.2) байгаа нь бусад насны бүлэгтэй харьцуулахад илүү байна. Харин 14 наснаасаа өмнө электрон тамхи татаж үзсэн суралцагчдын хувь 35.3% (95%CI 30.0-40.8) байв. Эрэгтэй суралцагчдын (37.8%, 95%CI 31.6-44.5) хувьд 14 наснаасаа өмнө электрон тамхи татаж үзсэн үзүүлэлт нь эмэгтэй суралцагчдаас (31.9%, 95%CI 29.9-43.7) 5.9 хувиар илүү байлаа. Харин байршлаар авч үзвэл хотод 36.5% (95%CI 26.7-42.3), хөдөөд 29.9 % (95%CI 23.6-37.0) нь 14 нас хүрэхээсээ өмнө электрон тамхи хэрэглэж үзсэн байна. Хүйсийн хувьд хот, хөдөөд ялгаагүй эрэгтэй суралцагчид илүү хэрэглэсэн байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. 14 наснаасаа өмнө электрон тамхи татаж үзсэн суралцагчдын хувь, хүйс, насны бүлэг, анги, байршлаар

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
Насны бүлгээр						
13-15 нас	51.9	47.3 - 56.5	57.4	51.3 - 63.3	45.5	37.3 - 53.9
16-17 нас	10.8	7.4 - 15.5	11.2	7.2 - 16.9	10.2	5.8 - 17.4
Анги						
8-р анги	82.2	76.5 - 86.8	84.1	77.3 - 89.2	81.2	71.2 - 88.3
9-р анги	40.0	34.1 - 46.3	44.9	35.5 - 54.7	33.1	26.1 - 41.0
10-р анги	15.6	11.7 - 20.4	20.4	13.5 - 29.6	10.5	6.5 - 16.5
11-р анги	12.1	6.9 - 20.4	11.6	5.9 - 21.6	-	-
12-р анги	4.1	1.1 - 14.0	-	-	-	-
Байршлаар						
Хот	36.5	29.9 - 43.7	39.5	31.3 - 48.3	32.7	24.6 - 42.0
Хөдөө	29.9	23.6 - 37.0	30.8	23.9 - 38.6	28.7	21.5 - 37.1
Нийт	35.3	30.0 - 40.8	37.8	31.6 - 44.5	31.9	25.3 - 39.3

Сүүлийн 30 хоногт тамхи худалдан авахаар оролдлого хийсэн суралцагчдыг насанд хүрээгүй гэж үзэн тамхи худалдахаас татгалзсан тохиолдол 38.2% (95%CI 31.2-45.7) байв. Үүнийг насны бүлгээр авч үзвэл насанд хүрээгүй, тамхи авахаар оролдлого хийсэн эрэгтэй суралцагчид (44.9%, 95%CI 35.6-54.6) эмэгтэй суралцагчдаас 18%-аар илүү байсан нь судалгаагаар тогтоогдлоо (Хавсралт 1).

3.6.4. Хэлцэмж

Бидний судалгаагаар суралцагчдын 19.9% нь тамхи татаж үзсэн байна. Тамхи татаж үзсэн суралцагчдын дийлэнх нь (56.5%, 95%CI 51.1-61.7) 14 түүнээс бага насандаа тамхийг сонирхож татаж үзсэн байна. Энэхүү үзүүлэлт нь хот, хөдөөгийн хувьд төдийлөн ялгаа ажиглагдсангүй.

Сүүлийн 30 хоногийн байдлаар суралцагчдын 11.1% (95%CI 9.0-13.5) нь хамгийн багадаа нэг өдөр тамхи татсан ба хөдөөд (20.5%, 95%CI 16.4-25.3) хотоос илүү байна. Энэ үзүүлэлт нь 2013 оны судалгаатай харьцуулахад 1.7%-аар нэмэгдсэн байгаа [8] нь сурагчдад тамхины хор хөнөөлийн талаарх мэдээллийг түлхүү өгч, анхаарлаа хандуулах хэрэгтэйг харуулж байна.

Дам тамхидалтад нийт суралцагчдын 63.2% (95%CI 59.4-66.8), үүнийг байршлаар авч үзвэл хотын суралцагчдын 64.4% (95%CI 59.4-69.1), хөдөөгийн суралцагчдын 58.7% (95%CI 53.6-63.6) нь тус тус өртөж байна. Сурагчид дам тамхидалтад өртөх байдал 2013 онд хийсэн судалгаагаар 60.8% байсан [8] бол энэ удаагийн судалгаагаар өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны судалгаагаар суралцагчдын электрон тамхины хэрэглээг анх удаа тогтооход 4 суралцагч тутмын 1 нь (24.8%, 95%CI 20.9-29.2) сүүлийн 30 хоногт электрон тамхийг татсан байв. Энэ үзүүлэлт нь хотод, тэр дундаа ахлах ангийн эрэгтэй суралцагчдын хэрэглээ их хэрэглэж байв.

3.6.5. Дүгнэлт:

1. 14 ба түүнээс бага насандаа тамхи татаж үзсэн суралцагчдын хувь 56.5% буюу 2013 оны судалгааны дүнгээс буурсан үзүүлэлттэй байна.
2. 4 суралцагч тутмын 1 нь электрон тамхи хэрэглэсэн бөгөөд анги ахих тутам энэ үзүүлэлт ихэсч байна.
3. Суралцагчдын дан тамхидалтад өртөж буй үзүүлэлт нь өмнөх оны судалгаанаас өссөн байна.
4. Суралцагчдын дунд тамхины хэрэглээ, тамхийг татаж үзэх, сонирхох зэрэг үзүүлэлтүүд нь төдийлөн буурахгүй байгаа нь ЕБС-ийн суралцагчдад чиглэсэн тамхи, түүний хор хөнөөлийг талаар мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, анхаарлаа хандуулах хэрэгтэйг харуулж байна.

3.7. АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Дэлхийн улс орнуудад хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад гэр бүлийн хүчирхийллийн 62.2%, зам тээврийн ослын 32.9%, гэмт хэргийн 12.4% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үед үйлдэгдсэн байдаг [37]. Мөн жил бүр 3 сая гаруй хүн архи, согтууруулах төрлийн ундааны буруу хэрэглээ, түүнээс шалтгаалсан нас баралт байгааг ДЭМБ-ын судалгааны дүнгээс харж болно [38].


Энэ бүлэгт ЕБС-ийн суралцагчдын согтууруулах ундааны хэрэглээ, хаанаас, хэрхэн олж хэрэглэдэг талаар тодруулж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, тогтоов.

Согтууруулах ундаа гэдэгт “архи, пиво, вино, виски, нэрмэл архи” зэргийг орно. “Ууж үзсэн” гэдэгт согтууруулах ундааг 1-2 удаа уруулдаа хүргэсэн, амссан зэргийг тооцоогүй, “НЭГ УУЛТ” гэдэг хэмжээгээр нь тооцсон болно. “Нэг уулт” хэмжээ гэдэгт нь нэг хундага дарс, нэг лааз шар айраг, нэг хундага архи, ликёр зэрэг бусад согтууруулах төрлийн ундааг 10 грамм этилийн спиртийн агууламж бүхий хэмжээгээр хэрэглэснийг тооцдог. “Согтох” гэдэгт согтууруулах ундаа хэрэглэсний дараа тэнцвэр алдагдах, хэл ээдрэх, бөөлжих, тасрах зэрэг шинжүүд илрэхийг тооцсон болно.

3.7.1. Суралцагчдын согтууруулах ундааны хэрэглээ

Нийт суралцагчдын 42.3% (95%CI 34.4-50.5) нь архи, согтууруулах ундааг 14 нас хүрэхээсээ өмнө хэрэглэж үзсэн байна (Зураг 15).

Зураг 15. 14 наснаасаа өмнө архи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн суралцагчдын хувь, байршил ба хүйсээр




Суралцагчдын 10.8% (95%CI 8.3-14.0) нь архи, согтууруулах ундааг сүүлийн 30 хоногт хэрэглэсэн ба энэ үзүүлэлт хотод (12.0%, 95%CI 8.7-16.3) хөдөөгөөс 2 дахин их байна. Мөн суралцагчдын 39.2% (95%CI 31.8-47.0) нь 2 уулт ба түүнээс дээш хэмжээгээр архи, согтууруулах ундааг хэрэглэсэн байна (Хүснэгт 12). Насны бүлгээр харахад 16-17 насны суралцагчид (43.8%, 95%CI 32.5-55.5) бусад насны бүлгээсээ их байв.

Хүснэгт 12. Согтууруулах ундаа хэрэглэсэн суралцагчдын хувь, хүйсээр (сүүлийн нэг сараар)

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
Архи, согтууруулах төрлийн ундаа хэрэглэсэн	10.8	8.3-14.0	11.2	8.2-15.1	10.5	7.7-14.0
2 уулт ба түүнээс дээш хэмжээгээр	39.2	31.8-47.0	43.2	32.4-54.7	35.1	26.3-45.0
6 уулт ба түүнээс дээш хэмжээгээр	13.8	8.8-21.1	17.3	11.0-26.1	10.7	5.4-20.2

Суралцагчдын 13.8% (95%CI 8.8-21.1) нь сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундааг нэг удаад уухдаа 6 уулт ба түүнээс дээш хэмжээгээр буюу хэтрүүлэн хэрэглэсэн байна. Байршлын хувьд хөдөөний суралцагчид хотын суралцагчдаас 7.3%-аар илүү хэрэглээтэй байсан (Зураг 16).

Зураг 16. Архи, согтууруулах ундааг 2 уулт болон 6 уултаас дээш хэмжээгээр хэрэглэсэн байдал, байршлаар



Суралцагчдын 22.7% нь (95%CI 16.2-30.8) найз, нөхдөөсөө архи, согтууруулах ундаа авч хэрэглэсэн нь 2013 оны судалгааны дүнгээс өссөн байна. Хүйсээр авч үзэхэд эмэгтэй суралцагчид (29%, 95%CI 19.9-40.1) илүү байлаа (Хавсралт 1).

Насанд хүрээгүй архи, согтууруулах ундаа худалдан авахыг оролдсон тохиолдол 50.4% (95% CI 39.8-61.0), гэр орны нөхцөлд согтууруулах ундааг хэрэглэж (66.1%, 95% CI 60.8-71.1), ямар нэг асуудалд орсон, эсхүл зодоон цохионд холбогдсон (3.8%, 95% CI 2.8-5.2) байдал байршлын хувьд ялгаагүй 16-17 насны эрэгтэй суралцагчдын хувьд илүү үзүүлэлттэй байна (Хавсралт 1).

Нийт суралцагчдын 14.5% нь нэг, түүнээс олон удаа согтож үзсэн байв. Үүнийг насны бүлгээр авч үзэхэд хот, хөдөөд ялгаагүй 16-17 насны суралцагчид (хот-22.4%, 95%CI 18.5-26.9, хөдөө-19.0%, 95%CI 14.3-26.4) илүү байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Нэг болон түүнээс олон удаа “согтотлоо уусан” суралцагчдын хувь, хүйс, насны бүлэг, байршлаар

Үзүүлэлтүүд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	(95%CI)	%	95%CI
Насны бүлгээр						
13-15 нас	10.7	8.3-13.8	11.4	8.6-14.9	9.9	6.9-13.9
16-17 нас	21.8	18.8-25.2	26.4	21.3-32.2	17.7	13.7-22.6
Байршлаар						
Хот	15.3	12.3-18.9	17.0	13.6-20.9	13.6	9.9-18.4
Хөдөө	11.7	8.5-15.8	15.0	10.4-21.1	8.5	5.5-12.9
Нийт	14.5	12.2-17.2	16.4	13.7-19.5	12.7	9.8-16.2

3.7.2. Хэлцэмж

Нийт суралцагчдын 42.3% нь 14 нас хүрэхээсээ өмнө согтууруулах ундаа хэрэглэж үзсэн бол эмэгтэй суралцагчдын хувьд 2013 онтой харьцуулахад 5.3%-аар нэмэгдсэн [8]. Харин эрэгтэй суралцагчдын хувь 6.2%-аар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Мөн суралцагчдын 10.8% нь сүүлийн 30 хоногт архи, согтууруулах төрлийн ундаа хэрэглэж үзсэн ба мөн өмнөх оноос 1.9%-иар нэмэгдсэн байна. Эмэгтэй суралцагчид найз нөхдөөсөө согтууруулах ундаа авч хэрэглэсэн байдал нь 2013 онтой харьцуулахад 7.7%-аар нэмэгдсэн нь ихээхэн анхаарал татаж байна. Мөн сүүлийн 30 хоногт 2 уулт болон түүнээс дээш хэмжээгээр хэрэглэсэн суралцагчдын хувь өмнөх судалгааны дүнгээс 14.4%-иар нэмэгджээ [8].



Манай улсын хувьд нийт суралцагчдын 10.8% нь сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундаа хэрэглэсэн нь Номхон далайн баруун бүсийн зарим орнуудын судалгааны үр дүнтэй харьцуулахад Индонез, Бруней Даруссалам гэх орнуудаас их, бусад бүх орнуудаас бага байна [27,39]. Мөн согтголоо ууж үзсэн сурагчид 14.5% байгаа нь Самоа, Индонез, Бруней Даруссалам, Фижи арал улсуудаас их байна. Харин 14 ба түүнээс доош насандаа согтууруулах ундаа хэрэглэж үзсэн сурагчид 42.3% байгаа нь Вануату, Лаос улсаас их байна [26,27,28,39,40,41].

3.7.3. Бүлгийн дүгнэлт:

1. 10 суралцагч тутмын 4 нь 2 уулт ба түүнээс дээш хэмжээгээр архи, согтууруулах ундаа хэрэглэж байгаа нь анхаарал татахуйц үзүүлэлт тул архины хор хөнөөлийн талаарх хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөтөлбөр үр дүн муутай байгаа нь харагдаж байна.
2. Суралцагчдын 50.4% нь архи, согтууруулах ундааг худалдан авч, хэрэглэж байгаа нь “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.
3. 6 уулт ба түүнээс дээш хэмжээгээр архи, согтууруулах ундаа хэрэглэсэн, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэр орон/ажлын байр, сургуулийн орчинд ямар нэг асуудалд орсон, зодоон цохионд холбогдсон суралцагчдын дийлэнх нь 16-17 насны эрэгтэй суралцагчид байв.
4. Эмэгтэй суралцагчид согтууруулах ундааг найз, нөхдөөсөө авч хэрэглэх хандлага эрэгтэй суралцагчдаас илүү байна.

3.8. Нөхөн үржихүйн эрүүл мэнд

Дэлхий дээр жил бүр 15-19 насны 21 сая орчим охид жирэмсэлснээс, тэдний 12 сая орчим нь хүүхдээ төрүүлдэг байна. Өсвөр насны охидын хүсээгүй жирэмслэлтийн 55% нь үр хөндөлтөөр төгсдөг нь маш аюултай [42].

Монгол улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 13068 эмэгтэйчүүд үр хөндүүлсэн нь өмнөх оноос 1025 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна. Үүний 626 тохиолдол буюу 4.8 хувийг өсвөр насны охидын үр хөндөлт эзэлж байна [5].

Өсвөр насны хүүхдүүд бэлгийн амьдралыг сонирхож эхлэх үеээс энэ талаар нээлттэй ярилцаж, бэлгийн боловсрол олгох нь цаашид үүсч болох эрсдэлээс сэргийлэх энгийн арга хэмээн олон улсад чухалчилдаг [43].

Бэлгийн боловсрол гэх ойлголтод нөхөн үржихүй, бэлгийн ариун цэвэр, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, жирэмслэлтээс хамгаалах арга гэх мэт олон зүйлс багтдаг.


Өсвөр насныханы хувьд эрт бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны үед бэлгэвч хэрэглэхгүй байх нь БЗДХ болон ХДХВ-ийн халдвар авах өндөр эсрдэлтэй гэдгийг олон олон судалгааны дүнгүүд харуулж байна.

Энэ бүлэгт суралцагчдын бэлгийн зан үйл, бэлгэвчний хэрэглээ болон жирэмслэхээс сэргийлэх аргын талаарх мэдлэг, хандлагыг судалсан.

3.8.1. Бэлгийн зан үйл

Нийт суралцагчдын 18.9% (95%CI 16.4-21.8) буюу ойролцоогоор 5 суралцагч тутмын 1 нь бэлгийн харьцаанд орж үзсэн байна. Бэлгийн харьцаанд орсон үзүүлэлт хотод 19.5% (95%CI 16.2-23.3) хөдөөд 16.6% (95%CI 13.5-20.2) байлаа (Зураг 17).

Зураг 17. Бэлгийн харьцаанд орсон суралцагчдын хувь, байршил ба хүйс




Бэлгийн харьцаанд орсон суралцагчдыг хүйсээр авч үзвэл эрэгтэй 21.7%, 16.4% эмэгтэй ба насны бүлгийн хувьд 13-15 настай суралцагчдын 15.2%, 16-17 настай суралцагчдын 25.9% нь бэлгийн харьцаанд орсон байна. Насны бүлэг бүрт эрэгтэй суралцагчдын хувь эмэгтэйдээс 2.8-10.6%-аар тус тус илүү байна.

Суралцагчдаас бэлгийн харьцаанд орсон гол шалтгааныг тодруулахад “Миний бүх найзууд бэлгийн харьцаанд орчихсон учраас” гэж эрэгтэй суралцагчдын 4.0% (95%CI 2.1-7.8), эмэгтэй суралцагчдын 2.6% (95%CI 0.8-7.7) тайлбарлажээ (Хавсралт 1).

Бэлгийн харьцаанд орсон суралцагчдын 5.7% (95%CI 4.2-7.7) нь 2 ба түүнээс олон хүнтэй бэлгийн харьцаанд орсон байна. Энэ үзүүлэлт нь хотод 6.0% (95%CI 4.1-8.8), хөдөө 4.7% (95%CI 3.2-6.9) байв. Харин эрэгтэй 10 суралцагч тутмын 1 нь хоёр ба түүнээс олон бэлгийн хавьтагчтай байна (Зураг 18).


Зураг 18. Хоёр ба түүнээс олон хүнтэй бэлгийн харьцаанд орсон суралцагчдын хувь, байршил ба хүйсээр



Энэ үзүүлэлт нь нас болон анги ахих тутам нэмэгдэж байна (Зураг 19). Харин байршил болон насны бүлгийн хувьд хотын 13-15 насны суралцагчид 4.6% (95%CI 2.8 - 7.4), 16-17 насны

суралцагчид 8.7% (95%CI 5.5 - 13.4) байсан бол хөдөөд 13-15 насны суралцагчид 2.6% (95%CI 1.8 - 3.9), 16-17 насны суралцагчид 9.3% (95%CI 5.5 - 15.5) тус тус байна.

Зураг 19. Хоёр ба түүнээс олон хүнтэй бэлгийн харьцаанд орсон суралцагчдын хувь, насны бүлгээр



Бэлгийн харьцаанд орсон суралцагчдын 24.3% (95%CI 15.8-35.5) буюу 4 суралцагч тутмын 1 нь 14 нас хүрэхээсээ өмнө бэлгийн харьцаанд орсон байна. Үүнийг хүйсээр авч үзвэл эрэгтэй суралцагчид 19.4% (95%CI 11.2-31.4), эмэгтэй суралцагчид 30.4% (95%CI 20.2-43.0)-тай байлаа (Хавсралт 1).


3.8.2. Бэлгэвч, жирэмслэхээс хамгаалах аргын хэрэглээ

Бэлгийн харьцаанд орсон нийт суралцагчдын 63.9% (95%CI 55.8-71.3) үүнээс эрэгтэй суралцагчид 70.8% (95%CI 63.9-76.9), эмэгтэй суралцагчид 55.1% (95%CI 43.3-66.4) нь хамгийн сүүлд бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна (Зураг 20).

Байршлын хувьд авч үзвэл хөдөөд 70.1% (95%CI 62.2-76.9), хотод 63.2% (95%CI 52.7-72.5) байсан ба анги ахих тутам бэлгэвч хэрэглэх хандлага нь нэмэгдэж байв (Хавсралт 1).

Бэлгийн харьцаанд орсон суралцагчдын 3.4% (95%CI 2.1-5.5) нь хамгийн сүүлд бэлгийн харьцааны үед бэлгэвчнээс бусад төрлийн жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэл хэрэглэсэн байна (Зураг 20). Энэ үзүүлэлт нь хүйсийн хувьд ялгаатай байдал ажиглагдаагүй ч хотын суралцагчдын хувьд илүү байлаа (Хавсралт 1).

Зураг 20. Сүүлийн бэлгийн харьцааны үед бэлгэвч болон жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгсэл хэрэглэсэн суралцагчдын хувь, хүйсээр



Бэлгийн амьдрал, бэлгийн зан үйлийн талаар эцэг эх, асран хамгаалагчтайгаа ярилцдаг суралцагчид 37.0% (95%CI 34.3-39.8), үүнээс 35.7% (95%CI 31.9-39.8) эрэгтэй, 38.2% (95%CI 35.3-41.3) эмэгтэй нь байна.

Харин 13-15 насныхан (41.8%, 95%CI 38.8-44.7) болон хөдөө (42.4%, 95%CI 39.3-45.5) орон нутгийн суралцагчид энэ талаар эцэг, эхтэйгээ илүү ярилцдагыг судалгаагаар тогтоолоо.

3.8.3. Хэлцэмж

Суралцагчдын 18.9% нь бэлгийн харьцаанд орж үзсэн ба 2010, 2013 оны судалгааны дүнгээс өссөн байна. Мөн хүйсийн хувьд энэ үзүүлэлт нь ойролцоогоор хоёр дахин өссөн үзүүлэлттэй байна.

Индонези улсад 2015 онд хийгдсэн судалгаагаар суралцагчдын 5.2% нь бэлгийн харьцаанд орсон байна [27]. Энэ үзүүлэлт ДЭМБ-ийн Номхон далайн баруун бүсийн орнууд болох Лаосд 2015 онд хийгдсэн судалгаагаар 15.1%, Самоад 2017 онд хийгдсэн судалгаагаар 24.8%, Брунэйд 2019 онд хийгдсэн судалгаагаар 5.7% тус тус байна. Эдгээр судалгааны дүнтэй харьцуулахад манай улс нь Индонези, Брунэй улсын суралцагчдаас 3 дахин их, Самоа улсын суралцагчдын үзүүлэлтээс бага байна [26,27,28,39,40,41].

Манай улсад 2018 оноос ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн цогц боловсрол олгох хичээл модулиар орж эхэлсэн. Гэсэн хэдий ч энэ удаагийн судалгаагаар өсвөр үеийнхний бэлгийн амьдрал болон зөв зан үйлтэй холбоотой асуудлууд анхаарал татахаар байна. Тиймээс цаашид ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийг үнэлэх, шинэчлэх, эрүүл мэндийн боловсрол олгож байгаа багш, нийгмийн ажилтнуудын чадавхийн нэмэгдүүлж, суралцагчдад мэдлэг, мэдээллийг чанартай хүргэх, тулгамдаж буй асуудлаа илэрхийлэх таатай орчин бүрдүүлэх зэрэг арга хэмжээг цогцоор нь зохион байгуулах шаардлагатай байна.

3.8.4. Бүлгийн дүгнэлт:

1. 5 суралцагч тутмын 1 нь бэлгийн харьцаанд орсон ба энэ үзүүлэлт эрэгтэй суралцагчдын хувьд аль ч насны бүлэгт илүү.
2. 4 суралцагч тутмын 1 нь 14 нас хүрэхээсээ өмнө, эрэгтэй 10 суралцагч тутмын 1 нь хоёр ба түүнээс олон хүнтэй бэлгийн харьцаанд орсон байна.
3. Бэлгийн харьцаанд орсон 2 суралцагч тутмын 1 нь хамгийн сүүлийн бэлгийн харьцааны үед бэлгэвч хэрэглэсэн ба эрэгтэй суралцагчдын дунд илүү байв.
4. 3 суралцагч тутмын 1 нь бэлгийн амьдрал, бэлгийн зан үйлийн талаар эцэг, эхтэйгээ ярилцдаг байна.

3.9. Хамгаалах хүчин зүйлс

Сургуулийн орчин ихэнх өсвөр үеийнхэнд гэр бүлээс хол, бие даах чухал орчин болдог. Таатай харьцаа, өөртөө итгэлтэй байхыг дэмжсэн ээлтэй орчинд хүүхэд, өсвөр үеийнхэн, багш нар, найз нөхөд, хам олонтойгоо найрсаг, эерэг харьцаатай, зохион байгуулалт сайтай байдаг. Тиймээс тэдэнд тулгарах эрсдлээс урьдчилан сэргийлэхэд гэр бүл, сургуульд аюулгүй орчин бүрдүүлэх нь ирээдүйн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх, эерэг харилцаа холбоог үүсгэх хамгааллын хүчин зүйл болдог байна [44].


Энэхүү бүлэгт суралцагчдын шалтгаангүйгээр хичээл таслалт, ангийн бусад суралцагчдын зүгээс хичээл сурлагад анхаарсан эсэх, эцэг эх, асран хамгаалагч нар тэдний гэрийн даалгавараа хийсэн эсэхийг шалгадаг, сэтгэл зовоосон асуудалд эцэг, эх асран хамгаалагч нар ойлгож, дэмдэг байдал, чөлөө цагаа хэрхэн өнгөрөөж байгааг мэддэг болон тэдний эд зүйлсэд зөвшөөрөлгүй хүрдэг зэрэг хүүхдэд тавих анхаарал, халамжийн талаар тандан судалсан.

Нийт суралцагчдын 26.5% (эрэгтэй-27.8%, 95%CI 23.8-32.1, эмэгтэй-25.2%, 95%CI 20.5-30.7) нь сүүлийн нэг сард ямар нэгэн шалтгаангүйгээр хичээлээ тасалсан байна. Эрэгтэй суралцагчдын

шалтгаангүйгээр хичээл таслалт эмэгтэйгээс суралцагчдаас илүү байгаа ч статистик ач холбогдол бүхий ялгаатай ажиглагдаагүй.

Харин байршил, насны бүлгээр харьцуулан авч үзвэл хөдөөгийн суралцагчид (32.2%, 95%CI 29.3-35.3) шалтгаангүйгээр хичээл тасалсан байдал илүү байна (Зураг 21).

Зураг 21. Шалтгаангүйгээр хичээлээ тасалсан суралцагчдын хувь, байршил ба хүйсээр (сүүлийн нэг сараар)




Судалгаанд сүүлийн нэг сард ангийнхан болон бусад суралцагчдын зүгээс хичээл сурлагад нь хэр анхаарч байсан талаар асуухад 55.3% (95%CI 51.5-59.0) нь миний хичээл, сурлагад байнга анхаарч байсан гэж хариулжээ. Тухайлбал, найз, нөхдөөсөө хичээл, номондоо дэмжлэг, тусламж авсан байдал нь:

- 8 дугаар ангийн суралцагчид - 54.1%, (95%CI 48.3 - 59.9)
- 9 дүгээр ангийн суралцагчид – 53.6%, (95%CI 48.9 - 58.2)
- 10 дугаар ангийн суралцагчид – 55.3%, (95%CI 47.4 - 63.0)
- 11 дугаар ангийн суралцагчид – 61.1%, (95%CI 47.9 - 72.8)
- 12 дугаар ангийн суралцагчид – 51.8%, (95%CI 39.9 - 63.5) тус тус байна.

Сүүлийн нэг сард эцэг эх, асран хамгаалагч нар нь хүүхдийнхээ гэрийн даалгавраа хийсэн эсэхийг тогтмол шалгаж байсан нь 21.5% (95%CI 19.8-23.3)-тай байв. Суралцагчдын нас, анги ахих тутам эцэг эх, асран хамгаалагч нарын зүгээс тэдний гэрийн даалгавраа хийсэн эсэхэд хяналт тавих нь буурч байв (Зураг 22).


Зураг 22. Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ гэрийн даалгаварт тавих хяналт, хүйс ба байршлаар



Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ сэтгэлийг зовоож буй асуудлыг огт ойлгож, дэмждэггүй гэх суралцагчид 57.3% (95%CI 54.4-60.2)-тай байсан бөгөөд ялангуяа эрэгтэй суралцагчдын (60.6%, 95%CI 57.1-64.0) дунд энэ үзүүлэлт илүү байлаа. Байршлын хувьд, хотод 57.1% (95%CI 52.9 - 61.3), хөдөөд 57.0% (95%CI 54.0 - 60.0)-тай байсан.

Нийт суралцагчдын 25.9% (95%CI 23.4-28.6) нь сүүлийн нэг сард эцэг эх, асран хамгаалагч нар нь тэдний чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг байдалд анхаарал хандуулдаггүй гэж хариулсан ба нас болон хүйсийн хувьд статистик ач холбогдолгүй байв. Харин байршлын хавьд, хотын суралцагчдын эцэг, эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ чөлөөт цагийг хэрхэн өнгөрөөж буй тал дээр анхаарал хандуулдаггүй байдал нь хөдөөгөөс илүү байлаа (Зураг 23).

Зураг 23. Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэгт эцэг эх, асран хамгаалагч нар нь анхаардаггүй байдал, хүйс ба байршлаар



Сүүлийн нэг сарын хугацаанд эцэг эх, асран хамгаалагч нар нь тэдний эд зүйлсэд зөвшөөрөлгүйгээр хүрсэн тохиолдол 80.7% (95%CI 78.0-83.3) байна (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Эцэг эх, асран хамгаалагч нар эд зүйлсийг нь зөвшөөрөлгүй хүрсэн суралцагчдын хувь, нас, хүйс, байршлаар

Үзүүлэлт	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%-CI
Насны бүлэг						
13-15 нас	79	76.5-81.3	80.3	76.8-83.4	77.7	74.9-80.3
16-17 нас	84	79.0-88.0	83.7	78.0-88.1	84.3	77.1-89.5
Байршил						
Хот	79.9	76.0-83.4	81.6	76.9-85.5	78.3	73.6-82.4
Хөдөө	82.8	80.3-85.1	81.2	76.6-85.1	84.4	82.2-86.3
Нийт	80.7	78.0-83.3	81.5	78.2-84.3	80.0	76.7-83.0

Хүснэгт 15. Хамгаалах хүчин зүйлсийн талаар асуултанд хариулсан суралцагчдын хувь, хүйсээр (сүүлийн нэг сараар)

Үзүүлэлт	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	%	95%CI	%	95%CI	%	95%CI
Нэг ба түүнээс олон өдөр шалтгаангүйгээр хичээлээ тасалсан	26.5	22.7-30.7	27.8	23.8-32.1	25.2	20.5-30.7

Ангийн болон бусад сурагчдаас чиний хичээл сурлагад байнга анхаардаг	55.3	51.5-59.0	55.5	50.7-60.3	55.2	51.0-59.3
Эцэг эх, асран хамгаалагчаас гэрийн даалгавар хийсэн эсэхийг байнга шалгадаг	21.5	19.8-23.3	24.3	21.4-27.4	18.8	16.4-21.4
Эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ сэтгэлийг зовоосон асуудлын талаар ойлгож дэмжсэн байдал	25.0	22.7-27.4	24.0	21.3-26.8	25.8	22.3-29.6
Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгааг эцэг эх, асран хамгаалагч нар нь анхаардаг байдал	57.2	53.7-60.6	57.6	54.1-61.1	56.9	52.4-61.2
Эцэг эх, асран хамгаалагч нар эд зүйлсэд нь зөвшөөрөлгүй хүрэх нь ихэнхдээ буюу байнга	80.7	78.0-83.3	81.5	78.2-84.3	80.0	76.7-83.0

Үр дүнгээс харахад суралцагчдын хамгаалах хүчин зүйлс буурсан буюу ялангуяа эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй байгааг илэрхийлж байна.

3.9.1. Хэлцэмж

Эцэг эх, асран хамгаалагч нар нь хүүхдийг өсгөх эрүүл, аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлж, сурах онцлогт нь тохирсон хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж, гэр бүлдээ болон сургуулийн орчинд эерэг хандлагатай болж төлөвшихөд чиглүүлэх үүрэгтэй билээ.

Манай улсын суралцагчдын шалтгаангүй хичээл тасалдаг (26.5%) байдлыг дэлхийн бусад оронтой харьцуулахад Филиппин 20.3%, Бруней 36.2%, Индонез 20.3%, Күүкийн арлын улсуудад 35.8% байна [27,31,39].

Энэ үзүүлэлтийг 2013 онд хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулахад 1.9%-иар өссөн байна.

Мөн суралцагчдын чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгааг эцэг эх, асран хамгаалагч нь анхаардаг эсэхийг бусад орнуудтай харьцуулан дүгнэхэд Индонезид 20.3%, Филиппинд 32.2%, Брунейд 47.3%, Бахрейнд 54.3% тус тус байсан бол Монгол улс нь 57.2% буюу илүү хувьтай байна [27,31,39]. Манай улсын энэ үзүүлэлт нь 2010 онд 43.3%, 2013 онд 48.8% байсан байна.

Цаашид өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн хувьд тулгарч болзошгүй эрсдэлт хүчин зүйлс, түүнээс гарах сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор гэр бүл, үе тэнгийнхэн, сургуулийн орчинд аюулгүй, хамгаалагдсан дэмжлэгт орчинг бүрдүүлэх чухал юм. Мөн эцэг эх, асран хамгаалагч болон хүүхэд хоорондын эерэг, найрсаг харилцааг бий болгосон дэмжлэгт үйл ажиллагааг зохион байгуулах, ур чадварыг эзэмшүүлэх шаардлагатай байна.

3.9.2. Бүлгийн дүгнэлт

1. Суралцагчдын 26.5% нь сүүлийн нэг сард ямар нэгэн шалтгаангүйгээр хичээлээ тасалсан байна. Байршил, насны бүлгээр харьцуулахад хөдөөний суралцагчид хотын суралцагчидээс 2 дахин илүү байна.
2. Эцэг эх, асран хамгаалагчдын 57.3% нь хүүхдийнхээ сэтгэлийг зовоож буй асуудлыг ойлгож, дэмждэггүй байна.
3. Суралцагчдын 25.9% нь эцэг эх, асран хамгаалагч нар нь хүүхдийнхээ чөлөөт цагийг хэрхэн өнгөрүүлж байгаад анхаарал хандуулдаггүй гэж хариулсан байна.



БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. Хооллолтын хэв маяг, хэрэглээ

Боловсролын орчин дахь суралцагчдын эрүүл мэндийн зан үйлийг тогтоохын тулд тэдний хоол, хүнсний хэрэглээ, эрүүл ахуй, осол гэмтэл, сэтгэцийн эрүүл мэнд, архи, тамхины хэрэглээ, бэлгийн зан үйл, хамгаалах зүйлсийн талаар судлан дараах дүгнэлтийг хийв. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын 14.5% нь илүүдэл жинтэй, 3% нь таргалалттай байх бөгөөд анги ахих тутам илүүдэл жин, таргалалтын хувь нэмэгдэж байна. Илүүдэл жин, таргалалт нь 2013 оны судалгааны дүнгээс хүйсийн хувьд ялгаагүй өссөн байна.
- Жимс, хүнсний ногоо хэрэглэх давтамж нь хотын суралцагчдын дунд их байна.
- 5 суралцагч тутмын 2 нь сүүлийн долоо хоногт нэгээс илүүгүй удаа хүнсний ногоо идсэн нь зохистой хооллолтын зөвлөмж хэмжээнд хүрэхгүй байна.
- 10 суралцагч тутмын 1 нь хийжүүлсэн болон чихэрлэг ундааг өдөрт нэг болон түүнээс олон удаа байв.

4.2. Эрүүл ахуйн дадал

- 10 суралцагч тутмын 9 нь өдөрт нэг ба түүнээс олон удаа шүдээ угаадаг зөв дадалтай байна. Энэ зөв дадал нь 16-17 насны бүлгийн эмэгтэй суралцагчдад илүү байв.
- 3 суралцагч тутмын 1 нь шүдээ угаахдаа фтортой оо хэрэглэдэг байна. Шүд угаах дадал нь байршил болон насны бүлгийн хувьд ялгаа ажиглагдаагүй.
- 2013 оны судалгаатай харьцуулахад шүдээ огт угаагаагүй суралцагчдын хувь 5.3-аас 6.5% болж өссөн. Харин эрэгтэй суралцагчдын хувьд огт угаагаагүй болон өдөрт нэгээс цөөн угаадаг буруу дадал 2013 онд 6.9% байсан бол 2023 онд 8.3% болж өсчээ.

4.3. Осол гэмтэл, хүчирхийлэл

- 5 суралцагч тутмын 2 нь осол гэмтэлд өртсөн байна. Энэ үзүүлэлт анги ахих тутам эрэгтэй суралцагчдын дунд илүү тохиолдож байна.
- 4 суралцагч тутмын 1 нь ноцтой бэртэж, гэмтсэн бөгөөд 2013 оны судалгааны үр дүнгээс буурсан байна.
- 3 суралцагч тутмын 1 нь бусадтай зодолдсон, сургууль орчимд дээрэлхүүлсэн бол 4 суралцагч тутмын 1 нь бусдад зодуулсан байна.
- 10 эрэгтэй суралцагч тутмын 1 нь, 5 эмэгтэй суралцагч тутмын 1 нь цахим дээрэлхэлтэд өртөж байна. Сөрөг утгатай зураг, бичлэг хүлээн авах, хэн нэгэн нийгмийн сүлжээнд бэлгийн харьцаатай холбоотой үйлдэл хийхийг албадсан зэрэг цахим дээрэлхэлтэд хот, хөдөөд ялгаагүй эмэгтэй суралцагчид илүү өртөж байна.
- 3 суралцагч тутмын 1 нь багшдаа шийтгүүлсэн, дарамтлуулсан байна. Энэ үзүүлэлт нь хот, хөдөөд ялгаагүй эрэгтэй суралцагчдад өндөр байна.

4.4. Сэтгэцийн эрүүл мэнд

- 10 суралцагч тутмын 1 нь дотны найзгүй, 4 суралцагч тутмын 1 нь байнга ганцаардаж, 10 суралцагч тутмын 4 нь амиа хорлох талаар бодож, 5 суралцагч тутмын 1 нь амиа хорлох талаар төлөвлөж байсан байна.
- 10 суралцагч тутмын 4 нь тухай хичээлийн жил эхэлснээс хойш сургууль дээрээ стресс, уур бухимдлаа хэрхэн зөв удирдах талаар хичээл, сургалтад хамрагдсан байна.

4.5. Тамхины хэрэглээ

- 5 суралцагч тутмын 2 нь тамхийг ганц, хоёр удаа сорж үзсэн, 2 суралцагч тутмын 1 нь 14 наснаасаа өмнө тамхиа татаж үзсэн, 4 суралцагч тутмын 1 нь электрон тамхи татаж үзсэн байна.
- 5 суралцагч тутмын 3 нь сүүлийн долоо хоногт нэг ба түүнээс олон өдөр дам тамхидалтад өртсөн бөгөөд байршил болон хүйсийн хувьд ялгаа ажиглагдсангүй.
- 10 суралцагч тутмын 1 нь хамгийн багадаа нэг өдөр янжуураас бусад төрлийн утаат тамхи болон хамрын тамхи гэх мэт утаагүй тамхи татсан байна.
- 10 суралцагч тутмын 3 нь 14 наснаасаа өмнө электрон тамхи татаж үзсэн байна.

4.6. Архи, согтууруулах ундааны хэрэглээ

- 5 суралцагч тутмын 3 нь гэртээ эсвэл хэн нэгний гэрт архи, согтууруулах ундаа хэрэглэсэн. 13-15 насны суралцагчдын хувьд илүү байв.
- 5 суралцагч тутмын 2 нь 14 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн ба энэ үзүүлэлт эмэгтэй суралцагчдын хувьд илүү, харин байршлын хувьд ялгаагүй байна. 2013 оны судалгаатай харьцуулахад эмэгтэй суралцагчдын согтууруулах ундаа хэрэглэж үзсэн байдал нэмэгдсэн байна.
- 5 суралцагч тутмын 2 нь сүүлийн нэг сарын хугацаанд согтууруулах ундааг 2 уулт ба түүнээс дээш хэмжээгээр, 5 суралцагч тутмын 1 нь найз нөхдөөсөө авч хэрэглэсэн байна.

4.7. Нөхөн үржихүйн эрүүл мэнд

- 5 суралцагч тутмын 1 нь бэлгийн харьцаанд орж үзсэн, 4 суралцагч тутмын 1 нь 14 наснаасаа өмнө бэлгийн харьцаанд орсон байна.
- 13-15 настай 5 суралцагч тутмын 1, 16-17 насны 3 суралцагч тутмын 1 нь бэлгийн харьцаанд орж үзсэн байна.
- Суралцагчдын 5.7% нь 2 ба түүнээс олон хүнтэй бэлгийн харьцаанд орсон ба энэ нь эрэгтэй суралцагчдын дунд илүү байна.
- 5 суралцагч тутмын 3 нь сүүлийн бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна. Энэ үзүүлэлт анги ахих тутам нэмэгдэж байв.
- 5 суралцагч тутмын 2 нь бэлгийн амьдрал, бэлгийн зан үйлийн талаар эцэг, эх, асран хамгаалагч нартайгаа ярилцдаг байна.

4.8. Хамгаалах хүчин зүйл

- 4 суралцагч тутмын 1 нь сүүлийн нэг сарын хугацаанд ямар нэгэн шалтгаангүйгээр хичээл тасалсан байна. Энэ үзүүлэлт хөдөөний суралцагчдад илүү байна.
- 5 суралцагч тутмын 3 нь эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ сэтгэл зовоосон асуудлыг ойлгож, дэмждэггүй гэж хариулсан.
- 5 суралцагч тутмын 4 нь эцэг эх, асран хамгаалагч нар нь ихэнхдээ буюу байнга тэдний эд зүйлсэд нь зөвшөөрөлгүй хүрдэг болон 5 суралцагч тутмын 3 нь тэднийг бусадтай харьцуулах, дооглож, тохуурхан, доромжилсон байдлаар харьцдаг гэж хариулсан байна.
- 4 суралцагч тутмын 1 нь чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгааг эцэг эх, асран хамгаалагч нар анхаардаггүй гэсэн бол 3 суралцагч тутмын 1 нь тэдний найзалж байгаа найзуудынхаа талаар мэддэг гэж тус тус хариулжээ.



ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

НЭГ. Холбогдох байгууллага, албан тушаалтанд

1.1 Хооллолт, эрүүл ахуйн дадал

- Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах
- Сурагчдад хичээлийн завсарлагаар дасгал, хөдөлгөөн хийх боломжит орчныг бий болгох
- Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөөний хүртээмжийг нэмэгдүүлэх
- Гар болон шүдээ тогтмол угаахын ач холбогдолыг ухуулан, таниулах зорилтот үйл ажиллагааг зохион байгуулах,
- Бүх шатны боловсролын байгууллагад хичээлийн жилийн эхэнд эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх талаарх үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусгах, үр дүнг дүгнэх, үнэлэх

1.2 Осол гэмтэл, хүчирхийлэл, сэтгэц, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хамгаалал

- Өсвөр насныхны бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэл, халдлагад өртөх зэрэг гэмт хэргийн шинжтэй тохиолдолд авах арга хэмжээг зураглан батлах, үндэсний хэмжээнд мөрдүүлэх, суралцагчдад танулах
- Өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэнд, хүүхдийн эрх хамгаалал, нөхөн үржихүй, бэлгийн амьдралын тулгамдсан асуудлын талаар статистик мэдээг бүх шатны боловсролын байгууллагад хүргүүлэх, авах
- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, түүнээс үүдэх сөрөг үр дагаварын талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нөлөөллийн ажлыг тогтмол хийх, бүх шатны боловсролын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах

1.3 Архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээ

- Архи, согтууруулах ундаа, тамхины хор уршгийн талаар суралцагч, тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч нарт зориулсан арга хэмжээг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах
- Архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээ, буруу дадал, донтолт, эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийн талаар сургалтын хөтөлбөрт оруулах
- Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай хуулийг таниулах ухуулга, нөлөөллийн арга хэмжээг тогтмол хийх

ХОЁР. Сургуулийн удирдлага, холбогдох ажилтнуудад

2.1 Хооллолт, эрүүл ахуйн дадал

- Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах тухай журмын хэрэгжилтийг хангах зорилгоор бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
- “Үдийн хоол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хоол хүнсэнд агуулагдах үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын хэмжээ нь зөвлөмж хэмжээнд байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол хяналт тавих,
- Эрүүл зохистой хооллолтын талаар мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах
- Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөөний хүртээмжийг сайжруулах
- Ариун цэврийн өрөөг гар угаалтуур, гарын шингэн саван, гар ариутгагч, нойлын цаас, зориулалтын жорлонгийн суултуур зэргээр хангах
- Суралцагчдад нас, хүйсийн ялгаатай байдлаар ариун цэврийн өрөө хэрэглэх боломжоор хангах



2.2 Осол гэмтэл, хүчирхийлэл, нөхөн үржихүй, сэтгэцийн эрүүл мэнд, хамгаалал

- Сургуулийн хашаанд шаардлагатай хаалт, нэмэлт тэмдэглэгээ хийх
- Багш, ажилтнуудыг цахим халдлага, зодоон, дээрэлхэлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар сургалтад тогтмол хамруулах, санал солилцох
- Сургуулийн бүх ажилтнуудад суралцагчдын нууц хадгалах талаар ойлголт өгөх, гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг танилцуулах
- Сургуулийн эмчийг сэтгэцийн эрүүл мэнд, нөхөн үржихүй, хамгааллын талаар сургалтад тогтмол хамруулах
- Дээрх асуудлуудаар эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад улирал тутам сургалт хийх, нээлттэй ярилцах боломжит орчныг бүрдүүлэх, гаргасан санал, санаачлагыг дэмжих
- Багш, эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад тулгамдсан асуудлыг мэдээлэх нууцлалын хайрцагтай болох
- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, учрах эрсдлийн талаар нээлттэй самбар байрлуулах, мэдээллийг ахлах анги бүр хуваарийн дагуу шинэчлэн түгээх арга хэмжээг зохион байгуулах

2.3 Архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээ

- Архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээний хор уршгийн талаар суралцагч, тэдний эцэг, эх, асран хамгаалагч нарт зориулсан үйл ажиллагааг санаачлах
- Сурагчийн клуб, зөвлөл байгуулж, архи, тамхины хор, хөнөөлийн талаар үйл ажиллагааг тогтмолжуулах, урамшуулан дэмжих
- Суралцагчдийн гэр бүлд архины хамааралтай хүн байгаа эсэх талаар бүртгэл хөтлөх, учрах эрсдлийг таамаглах, сэргийлэх арга хэмжээ авах, бие махбодь, сэтгэцийн эрүүл мэндийг хянах
- Сургуулийн орчинд архи, согтууруулах ундаа, бүх төрлийн тамхины худалдааг хянах, дээд шатны байгууллагад мэдээллэх
- Архи, согтууруулах ундаа, бүх төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүнийг худалдан авах нь хориотой талаар суралцагчдад мэдээлэл өгөх, анхааруулах, хариуцлага тооцож хэвших
- Хамгаалалтгүй бэлгийн харьцаа, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн улмаас үүсч болох эрсдлийн талаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан арга хэмжээ, сургалт зохион байгуулах

ГУРАВ. Эцэг эх, асран хамгаалагч нарт

3.1. Хооллолт, эрүүл ахуйн дадал

- Хүүхдийнхээ өдөр тутамд идэж буй хоол хүнсэнд хяналт тавих, эрүүл бус хооллолтын талаарх мэдээ, мэдээллийг олон нийтийн сувгаар дамжуулан олж авах, мэдээллээ солилцох, ярилцах
- Гараа угаах, шүдээ тогтмол угаах, усанд орж, ариун цэвэр сахих зэрэг эрүүл ахуйн зөв дадалтай болгох орчинг бүрдүүлж өгөх, хэвшүүлэхэд туслах
- Зохистой хооллолт, эерэг эрүүл ахуйн дадалд суралцаж буй байдлыг нь урамшуулах, дэмжих

3.2 Осол гэмтэл, хүчирхийлэл, нөхөн үржихүй, сэтгэцийн эрүүл мэнд, хамгаалал

- Суралцагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс сургуулийн орчин, хашаа, хаалга, зам зэрэгт шаардлагатай хаалт, аюулгүйн тэмдэглэгээ нэмж байршуулах талаар санал гаргах, шаардах
- Хүүхдийнхээ цахим хэрэглээнд хяналт тавих, хязгаарлах, шаардлагатай тохиолдолд багш нартай хамтран ажиллах
- Багш, сургуулийн ажилтнуудыг хүндэтгэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх, хүүхдүүдэд үлгэрлэх
- Сургуулийн орчин дахь дээрэлхэлт, зодоон, хүчирхийлэл зэрэг сөрөг хандлагыг бууруулах талаар сургуулийн удирдлага, анги хамт олонтой хамтран ажиллах, санал тавих
- Сэтгэцийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн асуудлаар нээлттэй ярилцах, хамгийн ойрын туслагч байхыг хичээх



- Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн хор уршгийг ойлгуулах, нээлттэй ярилцах, асуудал үүссэн нөхцөлд хамтран шийдвэрлэх
- Хүүхдийнхээ найз нөхөд, ангийн хамт олонтой танилцах, хамтарсан үйл ажиллагаанд оролцох, тэдгээрт эерэгээр нөлөөлөхийг хичээх
- Бусадтай харьцуулах, тэднийг үгүйсгэх, доромжлох, гутаах зэрэг сөрөг харилцаа, хандлагыг гаргахгүй байх, хувь хүн талаас нь харилцан ярилцдаг, хамтран шийдвэр гаргадаг, хүндэтгэн харьцахыг хичээх

3.3 Архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээ

- Хүүхдүүдийнхээ хажууд архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээгээ хязгаарлах, тэднийг дам тамхидалтад өртүүлэхгүй байх, буруу үлгэр үзүүлэхгүй байх
- Хүүхэдтэйгээ болон найз нартай нь архи, согтууруулах ундаа, тамхины хор уршиг, сэтгэцэт нөлөөлөх нөлөө, донтолт зэрэг сөрөг нөлөөллийн талаар ярилцах, зөвлөгөө өгөх

ДӨРӨВ. Суралцагчдад

4.1 Хооллолт, эрүүл ахуйн дадал

- Зөв, зохистой хооллолтын талаар үнэн зөв мэдээллийг олон нийтийн сүлжээгээр дамжуулан олж авах, бусадтайгаа хуваалцах
- Шим тэжээл муутай, муудсан, хугацаа дууссан зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авахгүй байх
- Шүдээ өдөрт 2-3 удаа угаах, хоол идэхийн өмнө болон ариун цэврийн өрөөнд орсны дараа, бохирдсон үед гараа тогтмол угаах, 7 хоногт хамгийн багадаа 2-3 удаа усанд орох зэрэг хувийн ариун цэврийг сахиж хэвших, найз нөхөддөө үлгэрлэх
- Сургуулийн орчны ариун цэвэр, эрүүл ахуйн талаар эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн удирдагчдад мэдээлэл хүргэж, танилцуулж байх

4.2 Осол гэмтэл, хүчирхийлэл, нөхөн үржихүй, сэтгэцийн эрүүл мэнд, хамгаалал

- Замын гарцын тэмдэг, тэмдэглэгээг уншиж сурах, гэрлэн дохиог мөрдөх
- Бусдад таагүй сэтгэгдэл төрүүлэхээс зайлсхийх, зодоон, хүчирхийлэл, дээрэлхэлтээс ангид байх
- Суралцагч өөрөө болон хэн нэгэн хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлтэд өртсөн бол цаг алдалгүй сургуулийн удирдлага, ангийн багш, эцэг, эх, асран хамгаалагч нарт мэдээлэх, хамгаалах арга хэмжээ авах
- Цахим орчинг зүй зохистой ашиглах, нийгмийн сүлжээн дэх ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлтийг дэмжихгүй байх
